



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА,
СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

**МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСГИЙН 2019 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ,
2020 ОНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ,
“ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН”
ҮЕИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА
СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСГИЙН 2019 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ,
2020 ОНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ,
"ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН"
ҮЕИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Улаанбаатар хот
2020 он

Боловсруулсан: Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэл

Хаяг: Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн
Монголбанк “Д” байр Денверийн гудамж 15,
Улаанбаатар-13380 Монгол Улс

Утас: 976-11-450025, 976-11-450030

Факс: 976-11-311471

Цахим шуудан: Demberel.s@mongolbank.mn

Энэхүү товхимолд дурдагдсан тоон үзүүлэлтүүд, бусад тайлбар 2019 оны 4 дүгээр улиралд боловсруулагдсан бөгөөд Covid-19 цар тахлын нөлөөллийг тусгаагүй болохыг анхаарна уу.

Тус товхимолд дурдагдах аливаа дүгнэлт, дэвшүүлсэн санал нь судлаачийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Монголбанкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Зохиогчийн эрхээр хамгаалагдсан болно ©2020 он. Монголбанк, ЭЗССХ

ГАРЧИГ

I. Эдийн засгийн өсөлт: Бууралт айсуй	7
II. Хэрэглээний болон бусад үнийн өөрчлөлтийн хандлага	9
III. Өрхийн эцсийн хэрэглээний зардлын дефляторын өөрчлөлт ба хэрэглээний үнийн индекс	10
IV. Мөнгөний секторын гол үзүүлэлтүүдийн 3-р улирал, 2019 оны хандлагууд	12
V. Төсвийн тэнцэл, түүний санхүүжилт, Засгийн газрын нийт өрийн өөрчлөлт	18
VI. Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал.....	20
VII. Өрхийн эдийн засаг	21
VIII. Бизнесийн эдийн засаг	27
“Өндөржүүлсэн бэлэн байдлын” үеийн эдийн засгийн бодлого.....	29

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Мөнгө, санхүүгийн зарим үзүүлэлтүүдийн жилийн өөрчлөлт (%)	13
Хүснэгт 2. Өрхийн санхүүгийн цэвэр хөрөнгө (орлогын түвшингээр, сая төг)	23

I. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ: БУУРАЛТ АЙСУЙ

1. ДНБ III улиралд нэрлэсэн утгаараа 15.2% өссөн бол бодит өсөлт нь 4.4% болж өмнөх улирлуудаас буурав. ДНБ-ий дефлятор буюу үнийн индекс 11.4% байгаа нь эдийн засагт инфляцийн дарамт нэмэгдсэнийг харуулж байна. Эдийн засгийн өсөлтөд оруулсан хувь нэмрийн хувьд үйлчилгээний сектор урьдын адил хамгийн өндөр 2.5 нэгж хувь, аж үйлдвэр, барилга харьцангуй буурч хөдөө аж ахуйнхаас (0.2 ба 0.5 нэгж) доогуур болсон байна. 2019 оны гүйцэтгэлээр нэрлэсэн ДНБ 36.9 их наяд болж өмнөх оноос 4.5 их наяд төгрөг буюу 13.8% өсөв. Бодит ДНБ 19.0 их наяд төгрөг болж өмнөх оноос 5.1% (923.8 тэрбум төгрөг) өсөв. ДНБ-ий дефляторын өсөлт 8.3% байна.
2. Бодит өсөлтийн хувьд аж үйлдвэр, барилгын салбар ердөө 0.8% өссөн бол дефляторын өсөлт нь 18.2%, үйлчилгээний салбарын бодит өсөлт 6.0%, дефлятор нь 8%, харин хөдөө аж ахуйн салбарын хувьд бодит өсөлт нь дефляторынхаас бага зэрэг илүү байна. Улирлын нөлөөллийг арилгасан **ДНБ-ий III улирлын өсөлт 4.9%, эхний 3 улирлын байдлаар 5.9%, 2018 оны I-III улиралд 6.3%, 2017 оны I-III улиралд 6.1% байгаа нь ерөнхийдөө буурч буй хандлагыг илэрхийлж байна.** 2019 оны дүнгээр уул уурхай олборлох салбарын өсөлт нь -0.6%, бөөний ба жижиглэнгийн худалдаа 7.2% (нэрлэсэн өсөлт нь 11.9%, дефлятор нь 4.4%) өссөн байна.
3. Улирлаас улирлын өсөлт нь бизнесийн орчлын мөчлөгүүдийн үед ДНБ-ий хэлбэлзлийг илүү тодорхой харуулж чаддаг. Тухайлбал, 2016 оны эхний 2 улиралд сөрөг өсөлт буюу -0.9%, -1.0% харин III улиралд 5.3%, 4-р улиралд өсөлтгүй буюу 0.03% болсон байв. 2018 оны хувьд эдийн засаг тэлэлтийн мөчлөгт оршиж улирлаас улирлын өсөлт 3.0%, 2.0%, 1.1%, 3.4% байв. Гэвч **2019 оны эхний 3 улирлын өсөлт 0.2%, 1.2%, -0.01% жилд шилжүүлсэн өсөлт нь 1.1%, 6.4%, -0.05% байгаа нь 2017-2018 оны ихэнх улиралд байсан тэлэлтийн мөчлөг 2019 оны эхний улирлаас суларч бууралтын мөчлөгийн дохиог тодорхой илэрхийлж байна.** Энэ хандлага 2019 оны 4-р улиралд мөн үргэлжилж IV улиралд энэ өсөлт 0.3%, жилд шилжүүлсэн өсөлт нь ердөө 1.2% болов.
4. Үндсэн үнээр буй нийт нэмэгдэл өртгийн (GVA) бодит өсөлтийг тооцож байх нь эдийн засгийн өсөлтийг илүү нарийвчлалтай илэрхийлдэг тул цаашид ДНБ-ий өсөлтөөс гадна түүнийг тооцдог болох нь ач холбогдолтой. Энэхүү үзүүлэлт 2017 онд 4.1% (ДНБ-5.3%), 2018 онд 5.8%

(ДНБ-7.2%), 2019 оны эхний 3 улиралд 6.1% (ДНБ-6.3%), 2019 онд 5.1% (5.19) байна. Өөрөөр хэлбэл, 2017-2018 онд эдийн засгийн өсөлт 6% хүрээгүй байна. Энэ дохиог бодлогын түвшинд цаг алдалгүй анхаарах нь чухал бөгөөд хэдийгээр жилийн дүнгээрээ эдийн засгийн өсөлт 2019 онд 5.0% орчим гарах боловч улирлаас улирлын эдийн засгийн өсөлт буурах хандлагад орсон, экспортын гол түүхий эдүүдийн үнийн бууралт эсвэл зогсонги байдал, дотоодын хөрөнгө оруулалтын идэвхжлийн хандлага, 2020 оны эхний хагаст болох улс төрийн үйл явцын өрнөл зэргийг харгалзвал **эдийн засаг 2020 оны II хагасаас бууралтын мөчлөгт орох өндөр магадлалтай байна.**

- 4.1. Үйлдвэрлэлийн зөрүүний 2015-2019 оны хандлагыг харахад 2015 оны I улирлаас 2018 оны II улирал дуустал 14 улирал дараалан сөрөг тэмдэгтэй, 2018 оны III улирлаас 2019 оны II улирал дуустал эерэг тэмдэгтэй. Харин 2019 оны III улиралд сөрөг тэмдэгтэй болсон байна. Уул уурхайн бус үйлдвэрлэлийн зөрүү 2015/I–2017/III улирал дуустал сөрөг тэмдэгтэй, 2017/IV –2019/III улирал дуустал эерэг утгатай явж ирсэн байна. Уул уурхайн үйлдвэрлэлийн зөрүү 2015/I –2017/I улирал дуустал эерэг утгатай 2017/II–2018/III улирал дуустал сөрөг утгатай байснаа 2018/IV–2019/I улиралд бага зэрэг сэргэсэн ч 2019 оны II, III улиралд сөрөг мужид дахин очсон байна. Эндээс харах гол дүгнэлт бол Монголын эдийн засгийн өсөлт тогтвортой өсөлтийн гольдролд тууштай орж чадаагүй л байгаа бөгөөд хэдийгээр уул уурхайн бус секторуудын үйлдвэрлэлийн өсөлт 2017 оны эцсээс эерэг мужид орж буй ч уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлт тогтвортой биш учраас 2020 оноос үйлдвэрлэлийн зөрүү сөрөг мужид байх магадлалыг нэмэгдүүлж байна.
- 4.2. Потенциал үйлдвэрлэлийн өсөлтийн 2016-2019 оны хандлагыг харахад 2016 онд 1.7-2.3% хооронд байсан бол 2017-2018 оны III улирал дуустал улирал бүр өсөлттэй, 2018 оны IV улирлаас өсөлт нь буурч, 2019 оны эхний 3 улиралд 6% орчимд тогтворжиж байна. 2007-2019 онд потенциал үйлдвэрлэлийн дундаж өсөлт 7.2%, голч өсөлт нь 6.1%, стандарт хэлбэлзэл нь 3.7% байгаа бөгөөд гэхдээ 2020 онд энэхүү дундаж болон голч өсөлтөөс бодит өсөлт доогуур гарах магадлал өндөр байна.
5. Эдийн засгийн нийт эрэлтийн хувьд ч ижил хандлага үзүүлж байгаа бөгөөд өрхийн эцсийн хэрэглээний зардлын өсөлтөд оруулсан хувь нэмрийн хувьд эхний 3 улирлын байдлаар 4.3%, жилийн дүнгээр

6.5%, үндсэн хөрөнгийн хуримтлалынх 8.9%, жилийн дүнгээр 7.2%, материаллаг эргэлтийн хөрөнгийнх 0.6% ба -0.7%, экспорт 16.4% ба 8.8%, импорт 25.4% ба 18.7% болж **дотоод эрэлтээр эдийн засгийн өсөлт хангагдсан байна.**

6. Эрэлтийн талын бүрэлдвэрүүдийн хувьд ДНБ-ий дефлятор эхний 3 улирлын хувьд 9.9%, жилийн дүнгээр 8.9%, өрхийн эцсийн хэрэглээний зардлын дефляторын өсөлт 1.9% ба 4.6%, үндсэн хөрөнгийн хуримтлалын дефлятор -2.6% ба -2.0% байв.
7. Дефлятороор тооцсон худалдааны нөхцөлийн индекс 12.4%, жилийн дүнгээр 13.1% өссөн байна. Үндэсний статистикийн хорооноос 2015=100 суурь хийсэн худалдааны нөхцөлийн индексээр 2019 оны III улиралд худалдааны нөхцөл 97.7% болж муудсан бол харин 2019 IV улиралд 115.5% болсон. Экспортын үнийн индекс IV улиралд 114.1%, импортынх 98.8% болсон нь үүнд нөлөөлсөн байна.

II. ХЭРЭГЛЭЭНИЙ БОЛОН БУСАД ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХАНДЛАГА

1. Хэрэглээний үнийн индекс 2018 оны III улиралд (2015=100) 5.7% өсөж байсан бол 2019 оны III улиралд 9.0% болсон. Инфляцид импортын барааны нөлөөг сагсанд эзэлж буй хувь хэмжээг нь тооцож үзэхэд 2020 оны 1-р сарын байдлаар эзлэх хувь нь 38.7%, нөлөө нь 3.2% буюу 2020 оны 1-р сарын 5.6%-ийн инфляцийн 57.1% болж байна. (Нийт 373 бараа, үйлчилгээний сагсны 200 нь импортын бараа ба нийт жилийн 45.5%) Мөн энэ хугацаанд хөдөө аж ахуйн салбарын дефлятор эхний 3 улирлын байдлаар 2.0%, аж үйлдвэр, барилга 9.1%, үйлчилгээний салбар 9.5%, бүтээгдэхүүний цэвэр татварынх 9.3% байгаа нь **2019 оны III улирал болон эхний 3 улирлын байдлаар хэрэглээний салбар болон нийт эдийн засагт үнийн өсөлт нэмэгдэж бодит үйлдвэрлэлийн өсөлтөөс илүү хурдацтай өссөн хандлага гүнзгийрснийг харуулж байна.** ДНБ-ий дефляторын өсөлт 2019 оны I улиралд 9.7%, II улиралд 6.5%, III улиралд 10.3% байгаа нь хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтөөс илүү байна. 2019 оны 11 сарын байдлаар хэрэглээний үний ерөнхий индекс 5.2% (2018 оны мөн үед 8.1%), хүнсний индекс 9.5% (2018 он 7.6%) байна (2020 оны 1-р сарын 5.6%-ийн инфляцийн 1.2 нэгж буюу 22.3%-ийг мах махан бүтээгдэхүүний үний өсөлт эзэлж байна).
2. Салбаруудын үйлдвэрлэгчийн үнийн индексүүдийн өөрчлөлт нь

эдийн засаг дахь үнийн өөрчлөлтийн хандлага төдийгүй бизнесийн орчин, идэвхжил, хүлээлтийг илэрхийлэх чухал индикатор байдаг тул олон орны засгийн газар, төв банкнууд өргөнөөр хэрэглэдэг.

- 2.1. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн ерөнхий индекс 2019 оны 11 сарын байдлаар 6.7% (2018 оны мөн үе 8.6%), уул уурхайн олборлолтын салбарынх 5.4% (2018 оны мөн үе 9.6%), боловсруулах үйлдвэрлэлийнх 6.8% (2018 оны мөн үе 9.3%) байна.
- 2.2. Худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс харьцангуй доогуур өсөлттэй, (I улирал 2.9%, II улирал 5.3%, III улирал 1.3%) байгаа ч хэрэглээний үнийн индексээр засварласан борлуулалтын бодит өсөлт нь ердөө 3.3% байна. Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс 2019 оны эхний 3 улиралд өндөр өсөлттэй, 2018 оны мөн үеэс эрс өссөн байна. 2020 онд эдгээр хандлага ерөнхийдөө хадгалагдах ч ерөнхий эдийн засгийн нөхцөл байдал 2020 оны II хагасаас муудах нөхцөлд өөрчлөгдөж болно.
- 2.3. Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс агаарын тээврийн үнийн индексийн өөрчлөлтөөс гол нь хамаардаг бөгөөд 2019 оны I улиралд ерөнхий индекс нь 7.9%, агаарын тээврийнх 15.4%, II улиралд 6.2%, 10.5%, III улиралд 2.2%, 2.5% өссөн байна. Барилгын өртгийн ерөнхий индекс бол барилгын салбарын бизнесийн ерөнхий идэвхжлийг харуулах бөгөөд энэ индексийн хувьд 2019 оны I улиралд 11.5%, II улиралд 7.6%, III улиралд 1.6% байгаа нь 2018 оны сүүлийн 2 улиралтай харьцуулахад барилгын өртгийн индекс буурсан байна.
- 2.4. 2018 оны харгалзах улирлуудтай харьцуулахад 2019 оны I улиралд худалдааны нөхцөлийн индекс -3.2%, II улиралд -0.7%, III улиралд -6.5% буурсан бөгөөд үүнд экспортын үнийн индекс -11.2%, -10.6%, -17.5%, импортын үнийн индекс -8.3%, -10.6%, -11.7% байна. Ялангуяа III улиралд экспортын үнийн индекс -17.5%, импортын үнийн индекс -11.7% болж эрс буурсан нь гадаад зах зээлийн нөхцөл тааруу болж буйн тусгал юм.

III. ӨРХИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДЛЫН ДЕФЛЯТОРЫН ӨӨРЧЛӨЛТ БА ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

1. Өрхийн эцсийн хэрэглээний зардлын нэрлэсэн хэмжээ 2015-2019 оны улирлуудаар хэрхэн өөрчлөгдөж ирсэн, энэхүү нэрлэсэн хэмжээг

өрхийн эцсийн хэрэглээний зардлын дефлятороор болон 2010, 2015 оны суурьтай хэрэглээний үнийн индексээр засварласан бодит өөрчлөлт яаж явагдаж ирснийг шинжлэх нь арга зүйн хувьд төдийгүй өрхийн аж байдлын судалгаанд, эдийн засгийн өсөлтийн бодлогыг тогтвортой, хүртээмжтэй өсөлтийн бодлогод шилжүүлэхэд чухал ач холбогдолтой.

2. 2015-2019 оны улирал бүрээр ДНБ, өрхийн эцсийн хэрэглээний зардлын нэрлэсэн өөрчлөлтийг харахад 2015/III, 2015/IV, 2016/I, 2016/IV, 2017/IV, 2019/II улиралд өрхийн эцсийн хэрэглээний зардлын нэрлэсэн абсолют хэмжээ өмнөх улирлаасаа багассан. Гэхдээ сонирхолтой нь эдгээр 6 улирлын бууралтын зөвхөн хоёрт нь буюу 2015 оны IV улирал, 2016 оны I улиралд л ДНБ-ий нэрлэсэн хэмжээ мөн адил буурсан.
3. Нэрлэсэн ДНБ-ий хувьд авч үзвэл 2015/IV, 2016/I, 2017/III, 2018/III, 2019/I улирлуудад абсолют хэмжээ нь өмнөх улирлаасаа буурсан. Өөрөөр хэлбэл, улирлын нөлөөллийг арилгаагүй нэрлэсэн ДНБ-ий улирлаас улирлын абсолют өөрчлөлтөд улирлын нөлөөллийн хүчин зүйлс болон тухайн харьцуулж буй улирлуудын үнийн өөрчлөлт тус тус нөлөөлсөн гэсэн үг юм. Өрхийн эцсийн хэрэглээний зардлын бодит өсөлт болон дефляторын өөрчлөлт дараах байдалтай байна. **2019 оны эхний 3 улирлын байдлаар өрхийн эцсийн хэрэглээний зардлын бодит өсөлт харгалзан 3.2%, 6.1%, 12.4% байгаа бол өрхийн эцсийн хэрэглээний зардлын дефляторын өсөлт 7.0%, -0.3%, -0.6% байв. Дефляторын өөрчлөлтийн ийм төрх байдал байнга тохиолдоод байдаггүй бөгөөд тэр тусмаа хэрэглээний үнийн индекстэй ийм эрс зөрүүтэй байх нь ховор.** Ийм байдал зөвхөн 2016 оны I, III, IV улиралд тохиолдож байв. 2020 онд энэхүү дефляторын өөрчлөлт ба ХҮИ хоёрын харьцаа яагаад ийм гарч буйн учир шалтгааныг арга зүйн талаас нь 2020 оны эхний улирлын ДНБ-ий тооцоонд анхаарах нь чухал. 2019 оны жилийн эцсийн байдлаар ӨЭХЗ-ын бодит өсөлт 10.9%, дефляторын өсөлт 4.6% байна.
4. 2010 он болон 2015 оны суурьтай хэрэглээний үнийн индексээр өрхийн эцсийн хэрэглээний зардлын бодит өсөлт болон үнийн өөрчлөлтийг тооцож үзэхэд: а. 2010 ба 2015 он суурьтай ХҮИ-үүдийн хооронд тодорхой хэмжээний зөрүү байгаа бөгөөд үүнийг арга зүйн гэхээсээ илүү "суурийн үр нөлөө" ("base effect") гэж үзэж болохоор байна. б. 2010 он болон 2015 он суурьтай ХҮИ-ээр засварлаж тооцсон өрхийн эцсийн хэрэглээний зардлын бодит өсөлт 2018 оны II улирлаас эхлэн дефлятороор тооцсоноос ихээхэн зөрүүтэй, **ялангуяа 2019 оны II ба III улиралд эрс**

зөрүүтэй; тухайлбал, III улиралд 12.4% байхад II улиралд 1.5/2.9%, харин дефляторын өөрчлөлт эсрэгээр; III улиралд -0.6% байхад II улиралд 10.0/8.5% байгаа нь “суурийн үр нөлөө”-өөс гадна өрхийн эцсийн хэрэглээний зардлын хэмжээ, сагсны бүтцэд гарсан өөрчлөлт (“өрхийн эцсийн хэрэглээний зардлын сагс” гэж нэрлэж болно.) болон ХҮИ-ийн сагсны өөрчлөлттэй холбоотой байж болохоор байна. Ямар ч тохиолдолд өрхийн эцсийн хэрэглээний зардлын бодит өсөлт болон дефляторын өөрчлөлт сөрөг утгатай болох нь эдийн засгийн бууралтын дохиолол, индикатор гэж үзэж болно.

1. ДНБ-ий дефляторын өсөлт 2015-2019/I-III улирлуудад хамгийн өндөр өсөлттэй үе нь жил бүрийн II улиралд, өрхийн эцсийн хэрэглээний зардлын хувьд мөн ижилдүү хандлагатай, харин ХҮИ-ийн хувьд жил бүрийн IV улиралд хамгийн өндөр өсөлттэй байна. ДНБ-ий дефляторын өсөлт жил бүрийн I улиралд хамгийн бага, өрхийн эцсийн хэрэглээний зардлын дефлятор мөн ижил хандлагатай байгаа бөгөөд ХҮИ-ийн аль ч сууриар тооцсон өсөлт мөн ижил хандлагатай байна.

IV. МӨНГӨНИЙ СЕКТОРЫН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН III УЛИРАЛ, 2019 ОНЫ ХАНДЛАГУУД

1. 2019 оны III улиралд нийт болон M1 мөнгөний өсөлт өмнөх улирлуудаас удааширч 14%, 11.1% болов. Ийм хандлага нийт харилцах (ТСА), түүний дотор гадаад валютын харилцах, гадаад цэвэр актив (NFA)-ын өөрчлөлтөөс бусад бүх үзүүлэлтийн хувьд байна.
2. Нийт зээлийн үлдэгдэл болон дотоод цэвэр зээлийн өсөлт улирал дараалан буурсан, ялангуяа ДЦЗ-ийн өсөлт сөрөг утгатай (ийм өсөлт 2006/12, 2009/12, 2012/12, 2017/12 онуудад гарч байв.), харин гадаад цэвэр актив улирал бүр “дахин” өсөлттэй, III улирлын эцсээр 3 дахин өссөн байна. Арилжааны банкнуудын төв банкинд байршуулсан нөөцийн өсөлт 2019 оны эхний 3 улиралд харгалзан 75.6%, 51.3%, 53.4%, төв банкны мөнгө буюу суурь мөнгөний өсөлт 44.1%, 40.1%, 24.2% байгаа нь **банкны секторт гүйлгэн чадварын (liquidity) илүүдэл буурахгүй, арилжааны банкнуудын авир төрх зээл олголтын хувьд “болгоомжилсон” хандлага үүссэн, гадаад валют нөөцлөх сонирхол давамгайлсныг харуулж байна.**

Хүснэгт 1. Мөнгө, санхүүгийн зарим үзүүлэлтүүдийн жилийн өөрчлөлт (%)

	FXR	M2	M1	Cout	Ci	QM	RM	ToD	TCA	TD in FC	TD in DC	CA in FC	CA in DC	TLO	NFA	NDC	ER	MM	CBR	CBV	Нэрлэсэн ДНБ	ӨЭХЗ	
2006/12	15.5	34.8	21.6	27.9	38.3	23.3	32.3	48.2	12.7	62.5	25.7	23.1	5.0	42.3	98.5	-3.1	-4.6	1,019	50.9	-43.7		33.5	14.5
2007/12	39.4	56.3	53.0	48.5	50.3	77.9	45.8	49.7	76.4	60.8	109.3	24.1	53.4	68.1	19.1	80.5	0.4	1,072	32.3	45.2		24.2	26.1
2008/12	-34.3	-5.6	16.0	11.8	-10.5	9.6	8.4	-10.3	-4.1	-19.3	3.7	16.4	-11.6	28.2	-50.1	55.5	8.3	0.8708	21.0	16.4		31.7	49.9
2009/12	101.9	27.0	-13.3	-8.7	37.5	0.6	26.4	38.9	22.6	37.3	15.0	42.0	31.2	0.7	125.1	-6.2	13.8	1,005	106.4	227.8		-1.1	4.5
2010/12	72.4	62.5	36.2	39.8	58.0	77.7	29.2	48.5	107.8	62.1	110.0	21.4	105.5	23.0	79.8	25.9	-12.9	1,258	22.7	181.2		48.5	39.9
2011/12	7.1	37.0	33.3	37.3	32.6	50.4	75.5	41.1	30.6	45.5	59.0	29.5	2.0	72.8	11.9	76.4	11.1	0.7806	48.5	-20.2		35.0	25.9
2012/12	68.4	18.7	16.6	16.1	23.7	5.4	30.5	26.4	4.3	19.7	0.7	46.7	10.0	23.9	42.8	-7.6	-0.3	0.9096	36.6	-15.1		26.7	30.4
2013/12	-45.5	24.2	-3.5	1.5	27.4	14.1	52.2	29.8	18.9	40.9	22.7	2.9	13.4	54.0	-82.4	157.1	19.2	0.8160	77.1	117.7		14.9	20.9
2014/12	-26.60	12.5	-14.2	-3.7	19.8	-13.2	0.0	15.6	10.9	10.2	-12.8	33.5	47.7	16.1	-32.0	40.5	13.8	1,125	8.7	-47.6		15.7	17.7
2015/12	-19.81	-5.5	-8.1	-12.7	-5.2	-7.2	-25.4	0.0	-19.9	0.4	0.4	-1.1	-31.8	-6.4	-107.0	6.5	5.7	1,2668	-31.4	20.1		4.2	8.6
2016/12	-2.03	21.0	27.4	22.7	16.6	19.7	24.6	16.2	36.6	43.2	6.5	45.8	29.2	6.1	-10.1	14.8	24.8	0.9711	41.7	-43.7		3.4	-4.0
2017/12	132.04	30.5	31.6	8.7	10.0	30.2	28.6	30.0	35.8	-9.2	48.9	31.5	39.7	9.6	72.9	-2.5	-2.5	1,0148	15.8	497.1		16.3	13.6
2018/12	17.99	22.8	42.6	9.6	6.9	18.5	24.5	18.1	37.4	19.3	17.8	20.6	51.8	26.5	120.1	15.8	8.9	0.9863	33.1	29.1		16.0	10.0
2019I	22.71	22.6	32.1	6.8	6.8	20.6	44.1	23.5	22.3	15.3	25.8	3.3	38.9	23.5	169.3	9.5	10.0	0.8508	75.6	-14.7		15.6	10.4
2019II	37.20	16.6	22.4	1.6	0.6	15.3	40.1	18.0	15.4	17.4	18.1	1.0	27.3	18.3	288.3	2.6	7.9	0.8323	51.3	0.3		14.3	5.8
2019III	37.72	14.0	11.1	-9.9	-4.2	14.7	24.2	12.1	21.7	7.9	13.3	28.5	16.1	11.1	295.2	-4.0	4.5	0.9179	53.4	-9.7		19.6	11.8
2019IV																							

Эх сурвалж: Монголбанк

- Төчлөл:
M2 - нийт мөнгө
M1 - мөнгө
Cout - хадгаламжийн байгууллагаас садуурх мөнгө
Ci - гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө
QM - бусад хадгаламж
RM - нөөц мөнгө
ToD - нийт хадгаламж
TCA - нийт харилцах
TD in FC - гадаад валютын хадгаламж
FXR - Гадаад валютын албан нөөц
TD in DC - төгрөгийн хадгаламж
CA in FC - гадаад валютын харилцах
CA in DC - төгрөгийн харилцах
TLO - нийт зээлийн үлдэгдэл
NFA - гадаад цээр акти
NDC - дотоод цээр зээл
ER - валютын ханш
MM - мөнөөний үржүүлэгч
CBR - арилжааны банкуудын нөөц
CBV - төв банкны үнэт цаас

3. 2019 оны эхний 2 улиралд харьцангуй эрчтэй суларч байсан төгрөг, ам долларын солилцооны ханш III улиралд тогтворжиж 4.5% болсон нь **ГЦА-ын өндөр өсөлт болон гадаад валютын хадгаламжийн өсөлт удааширсан байгаатай нийцтэй байна.** Ханшийн сулрал багасах болон хэрэглээний үнийн индексийн өсөлтийн чиглэл (2019/3-6.7%, 2019/6-8.1%, 2019/9-9.0%) эсрэг байгаа нь **инфляцад ханшийн шилжих үр нөлөө буурч буйг харуулж буй ерөнхий дүр зураг юм.**
4. Мөнгөний үржүүлэгч (ММ) буюу суурь мөнгөний үржүүлэх чадварын үзүүлэлтийн хандлагыг харахад 2018/12 сараас эхлэн 2019 оны эхний 3 улиралд 1-ээс бага утга (2018/12-0.9863, 2019/3-0.8508, 2019/6-0.8323, 2019/9-0.9179) авсан байгаа нь 2008/12, 2011/12, 2012/12, 2013/12 онууд болон 2016/12 оны хандлагатай ижил байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн орчлын мөчлөгүүдтэй нийцсэн мөнгөний бодлогын төлөв, хандлагыг илэрхийлэх бөгөөд гэхдээ энэ нь нийт эдийн засгийн идэвхжилд эерэг, сөрөг нөлөөтэй байсан эсэхийг бас харгалзах нь чухал. Тухайлбал, 2019 оны эхний 2 улиралд ММ үзүүлэлт 1-ээс бага утгатай байсан нь эдийн засгийн өсөлт өндөр байсан тул төв банкны зүгээс халалтын шинж тэмдгүүд үүссэн гэж үзээд суурь мөнгөөр дамжуулан мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлсөн гэж онолын хувьд үзэж болох ч улирлын нөлөөллийг арилгасан ДНБ-ий улирлаас улирлын өсөлтийг харвал эдийн засаг "халах" биш харин ч "хөрөх" шинж тэмдэг ажиглагдаж буйг харгалзвал **мөнгөний бодлого, түүний төлөв зохистой байж чадаж байгаа юу гэсэн асуулт гарч байна.**
5. Нийт эдийн засагт инфляцийн дарамт нэмэгдсэн, хэрэглэгчийн болон үйлдвэрлэгчийн үнийн индексүүд өссөн өнөөгийн нөхцөлд ерөнхий онол арга зүйн хувьд мөнгөний бодлогын төлөв (stance) accommodative буюу нийцтэй эсвэл чангарах төлөв байдалтай байж болох бөгөөд энэ нь инфляци бол "мөнгөний үзэгдэл" гэдэг мөнгөний тооны онолын үндэслэл дунд болон урт хугацаанд хүчин төгөлдөр байна гэж үздэгтэй холбоотой юм. Монголын эдийн засгийн хувьд ч энэхүү үзэл номлол, үзэл баримтлалаас ангид биш юм. Үүний тодорхой жишээ нь нийт мөнгөний өсөлт ба нэрлэсэн ДНБ-ий өсөлтийн харьцаа бөгөөд энэ нь уг чанартаа М.Фридманы мөнгөний тооны онолтой нийцтэй байна.
6. M1 мөнгөний бүтцийг харгалзан ДНБ-ий нэг гол бүрэлдвэр болох өрхийн эцсийн хэрэглээний зардлын нэрлэсэн өсөлттэй харьцуулж болох бөгөөд энэ нь утгаа өрхийн секторын нэрлэсэн эрэлт болон мөнгөний хамгийн эргэлт сайтай бүрэлдвэр хоёрыг харьцуулж буй хэрэг тул сонирхолтой дүр зураг гарч болох юм. 2006/12-2018/12 оны хооронд

7 жилд нь өрхийн эцсийн хэрэглээний зардлын нэрлэсэн өсөлт М1 мөнгөний нэрлэсэн өсөлтөөс түрүүлж байсан бөгөөд харин М2 мөнгө ба нэрлэсэн ДНБ-ий өсөлтийн хувьд ердөө 4 жилд ДНБ-ий нэрлэсэн өсөлт түрүүлж байв. **Өөрөөр хэлбэл, М1 болон өрхийн эцсийн хэрэглээний зардлын нэрлэсэн өсөлт нь тухайн үеийн мөнгөний эдийн засаг, өрхийн эдийн засаг хоёрын холбоог илүү тодорхой харуулж байгаа бөгөөд орчлын мөчлөгүүдийг таньж мэдэхэд хэрэглэж болох чухал үзүүлэлт байж болохоор байна.**

7. Өөр нэг сонирхолтой харьцуулалт бол гадаад валютын нөөцийн жилийн өсөлт, ам доллар/төгрөгийн солилцооны ханшийн өөрчлөлт юм. Монголбанкны хувьд, миний бодлоор, эдийн засгийн бодлогын гэхээсээ улс төрийн бодлогын шахалтын “дилемма” үүсдэг бөгөөд учир нь нэг талаас валютын нөөцийг нэмэгдүүлэх ҮАБЗ-ийн зөвлөмж, жил бүр УИХ-аас баталдаг мөнгөний бодлогын баримт бичигт энэ зорилтыг тусгах шаардлага хэрэгцээ, нөгөө талаас УИХ-ын зүгээс валютын ханшийг “тогтворжуулах” (өөрөөр хэлбэл, нэг түвшинд байлгах хүсэл) хүсэлт шаардлага, ингэснээр **валютын нөөцийг үр ашгийг нь үл харгалзан интервенцийн зорилгоор ашиглах гэсэн дилемма үүсдэг.** Онолын болон бодлогын практикийн хувьд Монгол шиг валютын нөөц багатай улсын хувьд интервенц хийх гол зорилго, шаардлага нь ханшийн зах зээл дээр хэт их хэлбэлзэл үүсэхээс сэргийлэх, энэ чиглэлийн спекулятив хүчин зүйлсийг гаргуулахгүй байхад л оршдог. **“Валютын нөөцийн менежментийн гурвал” (trilogy of reserve management objectives) болох “аюулгүй байдал, гүйлгэн чадвар буюу төлбөр түргэн гүйцэтгэх чадвар ба (зөвхөн энэ хоёрыг хангасны дараа) нөөцийн өгөөж” (security liquidity and (only then) return) гэсэн талаас нь авч үзэх хэрэгтэй бөгөөд ялангуяа 2020–2024 онд менежментийн энэ хандлагыг онцгой анхаарах шаардлага үүсч байна.**
8. Өмнө дурдсан хоёр үзүүлэлтийг 2006/12-2018/12 хугацаанд авч үзвэл валютын нөөцийн өсөлт буурсан жилүүдэд ханшийн сулрал хамгийн өндөр байсан бөгөөд тухайлбал, 2013/12-2016/12 хугацаанд ийм хандлагатай байв. Харин валютын нөөцийн өсөлт эрс нэмэгдсэн жилүүдэд ханш чангарах хандлагатай байв. Ханш ихээхэн суларсан үед интервенцийн зорилгоор зарцуулсан валютын нөөцийн зардал үр өгөөж буюу интервенц хийсэн нь үр нөлөөгөө хэр хэмжээнд өгсөн бэ гэдгийг цаашид нарийвчлан тодорхойлох шаардлагатай бөгөөд интервенцийн тактик, ханшийн буюу банк хоорондын зах зээлийг цаашид тогтворжуулах чиглэлээр тодорхой судалгаа, бодлогын алхмууд шаардлагатай.

- 8.1. **2009–2019 онд интервенц хийсэн өдрүүдийн ажлын нийт өдөрт эзлэх голч утга 21%, арилжааны танкуудын валют худалдаж авах нэрлэсэн эрэлт голч дүнгээрээ 607.2 сая доллар, Төв банкны бодит нийлүүлэлт энэхүү эрэлтийн 31.6% хангасан буюу голч утга нь 192.1 сая доллар, 2019 оны эхний 2 улирлын дүнгээр 1161.4 сая доллар Төв банкнаас нийлүүлсэн нь валютын ханаагүй эрэлтийн хэмжээ нэмэгдсээр буйг харуулж байна.**
- 8.2. **Валютын зах зээл дээрх валютын цэвэр эрэлт (арилжааны банкнуудын) буюу тэдний валютын худалдан авах болон худалдах валютын саналын зөрүү (±) –ний 2009–2019 оны түүхэн хандлагаас харахад гадаад валютын албан нөөц, экспорт, импортын хэмжээний өөрчлөлттэй шууд хамааралтай, ханшийн чангаралт болон сулралтад нөлөөлсөн гол хүчин зүйл болж ирсэн байна.** 2009-2011 оны хооронд энэхүү цэвэр эрэлт бага зэрэг нэмэгдсэн эсвэл сөрөг тэмдэгтэй буюу буурч байсан бол 2012-2016 онуудад эрс нэмэгдэж 2012 онд жилийн дүнгээрээ 1948.2 сая \$, үүнийг хангасан Төв банкны цэвэр нийлүүлэлтийн хувь хэмжээ 32.8%, 2013 онд харгалзан 4852.1 сая \$ (түүхэн дээд хэмжээ), 25.2%, 2014 онд 3700.7 сая \$, 34.1%, 2015 онд 1977.3 сая \$, 40.3%, 2016 онд 2610.0 сая \$, 36.5% гэсэн байдалтай байсан бол 2017 онд жилийн дүнгээрээ -302.7 долларын илүүдэл эрэлттэй 2018 онд 2017.2 сая долларын цэвэр эрэлт, Төв банкны цэвэр нийлүүлэлтийн хувь хэмжээ нэмэгдэж 53.6% болсон байна. 2019 оны эхний 3 улирлын байдлаар Төв банкны цэвэр нийлүүлэлт 1801.2 сая доллар болсон ба энэ хугацаанд валютын ханшийн сулрал I улиралд 9.6%, 2-р улиралд 9.7%, III улиралд 7.7% болсон байна.
9. Мөнгөний нийлүүлэлтийн онолын талаас нь үзвэл нийт мөнгөний өөрчлөлтөд суурь мөнгөний хөдөлгөөнөөс гадна нийт депозит ба арилжааны банкнуудын нөөц мөнгө хоорондын харьцаа, нийт депозит болон банкнаас гадуурх мөнгөний өөрчлөлтийн харьцаа чухал ач холбогдолтой бөгөөд учир нь **дээрх 3 үзүүлэлтийн ард төв банкны мөнгөний бодлого, мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдвэрүүдийн өөрчлөлтийг зөв чиглэлд залах замаар макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилт агуулагдаж байдаг.**
10. **Төв банк ба арилжааны банкнуудын нэгдсэн тэнцэл 21.8% тэлж энэхүү өсөлтөд гадаад цэвэр актив (19.1%) голчлон хувь нэмэр оруулсан бол пассив талд нийт мөнгө (16.6%) түүний дотор M1**

мөнгө 4.3%, нийт хадгаламж, валютын харилцах 12.2% хувь нэмэр оруулжээ.

11. Нийт мөнгөний өсөлт 2019 оны 11 сарын эцсийн байдлаар 9.8% байгаа нь **2019 онд бүхэлдээ мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хурдац буурахыг харуулж байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд төгрөгийн хадгаламжийн өсөлт гол хувь нэмэр оруулахаар байгаа бол актив талаас гадаад активын өсөлт голлож дотоод активын хувь нэмэр эрс буурахаар байна.** Засгийн газрын хадгаламж, өр хоёрын зөрүү буюу цэвэр хадгаламжийн мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд оруулсан хувь нэмэр 2019 оны 11 сарын эцсийн байдлаар -9.3% байна.
12. Төв банкны суурь мөнгөний өсөлт 2019 оны III улирлын эцэст 24.2% өсөхөд заавал байлгах нөөцийн оруулсан хувь нэмэр 15.5%, илүүдэл нөөцийнх 9.8% байгаа бол актив талаас гол зэрэг хувь нэмрийг гадаад цэвэр активын өсөлт хангасан бол засгийн газрын цэвэр зээлийн өсөлт, бусад цэвэр зүйл, зах зээлийн цэвэр зээлийн зүйлийн өсөлт сөрөг хувь нэмэр оруулсан байна.
13. 2019 оны 11 сарын байдлаар Төв банкинд буй арилжааны банкнуудын төгрөгийн нөөц 18.2% нэмэгдсэн нь заавал байлгах нөөцийн хэмжээ нэмэгдэж чөлөөтэй нөөц нь багассантай холбоотой ба **энэ нь Төв банкнаас энэ чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогоор нөхцөлдсөн байна.** Харин валютын нөөц 18.2% буурсан нь заавал байлгах нөөцийн хэмжээ нэмэгдсэн ч (17.2%) чөлөөтэй нөөцийн хэмжээ 33.5% буурсантай холбоотой.
 - 13.1. Нийт нөөцөд валютын нөөцийн эзлэх хувь 54.3% болж 2018 онтой харьцуулахад арав гаруй нэгжээр буурсан ч валютын чөлөөтэй нөөцийн хувь хэмжээ өндөр байсаар байгаа нь **арилжааны банкнуудын нөөцийн бодлого, авир төрхийн хувьд дорвитой өөрчлөлт гараагүйг харуулж байна. 2020 онд, хулгана жилд энэ хандлага хадгалагдаж арилжааны банкнуудын "хөөе хураах" авир төрх зонхилсон байдал үргэлжлэхээр байна.**
14. Мөнгөний үзүүлэлтүүдийг авч үзвэл гадаад валютын харилцах валютын ханшийн өсөлт бууралттай төстэй хэлбэрээр өсч буурсан бөгөөд 2018 оны эцсээс эхлэн харгалзах улирлуудад 857.9, 755.6, 848.7 сая ам.доллар болон өөрчлөгдөж валютын хадгаламжийн ам.доллараар илэрхийлсэн дүн төдийлөн өөрчлөгдөөгүй байна. **Харин зээлийн өрийн үлдэгдэл**

сүүлийн улирлуудад буурч жилийн өсөлт 2018 оны эцэст 15.8% байсан нь оны эхний хагасын байдлаар 2.6% болж буураад байна.

V. ТӨСВИЙН ТЭНЦЭЛ, ТҮҮНИЙ САНХҮҮЖИЛТ, ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨРИЙН ӨӨРЧЛӨЛТ

1. 2006-2017 он хүртэл 9 жилд төсвийн хомстолтой, 3 жилд нь төсвийн илүүдэлтэй байсан эдийн засаг 2018-2019 онд төсвийн илүүдэлтэй; 2018 онд жилийн дүнгээрээ 11.9 тэрбум төгрөг, 2019 оны I улиралд 286.5 тэрбум, II улиралд 192.2 тэрбум, III улиралд 545.4 тэрбум төгрөгийн илүүдэлтэй болсон нь ДНБ-ий 3.6-5.6%-тай тэнцэж байна. Гэхдээ 2006/12-2019/9 хугацаанд төсвийн хомстол/илүүдлийн абсолют болон харьцангуй хэмжээнээс гадна (ДНБ-д харьцуулсан) мөн энэ хугацаанд засгийн газрын нийт өрийн өөрчлөлт болон төсвийн хомстол/илүүдлийн нийлбэр дүнг ДНБ-д харьцуулж үзвэл өөр дүр зураг гарч байна. Өөрөөр хэлбэл, "нөөц-урсгалын зохицолдоо" (stock-flow adjustment) буюу мөн "төсвийн арга мэх" ("fiscal gimmick") гэсэн үзүүлэлтүүдийг гадаад, дотоод нийт өрийн хэмжээний өөрчлөлтөөр тооцож төсвийн хомстол/илүүдэлтэй хамт авч үзнэ гэсэн хэрэг юм. **Энэхүү үзүүлэлтийг 2007/12-2019/9 оны байдлаар нийт 13 жилийн ихэнхэд нь буюу 8 жилд нь энэхүү үзүүлэлт эерэг тэмдэгтэй гарч байгаа нь бусад хөгжиж буй улсуудын адил "төсвийн арга мэх" буюу "төсвийн нуугдмал хомстол" бодитойгоор "prima facie" түвшинд оршиж ирснийг харуулж байна.**
2. Эдгээр 8 жилийн дотор нь аваад үзэхэд уг үзүүлэлт сонгуулийн өмнөх/ дараах болон сонгуулийн жилүүдэд илүү өндөр хувьтай (ДБН-д харьцуулсан харьцаа нь 2009-17.7%, 2012 онд 21.9%, 2016 онд 30.1%, 2019 онд 16%) байгаа нь **сонгуулийн орчлын нөлөө хүчтэй байдгийг харуулж байна.** 2019 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлээс үзэхэд 2018 оны эцсээр бий болсон эерэг хандлага 2019 оны I-III улиралд үргэлжилсэн ч 2019 оны жилийн эцсийн дүнгээр төсвийн хомстол -627.8 тэрбум (12 сарын эцсээр -1114.5 тэрбум) төгрөг болж 2020 оны төсвийн хүрээний мэдэгдлээр -2.1 их наяд хүрэхээр байгаа нь **төсвийн тогтвортой байдлын гол үзүүлэлтүүдийн харьцаа муудаж болох бодитой эрсдэлүүд үүсэхээр байна.** Энэ хандлага нь "нөөц-урсгалын зохицолдоо" мөн эерэг тэмдэгтэй гарч болохыг нөхцөлдүүлж байна.

- 2.1. Эдийн засагч Л.Даваажаргал, О.Цолмон нарын судалгаагаар ("Төсвийн бодлого эдийн засгийн өсөлтийг дэмждэг үү?" 2019 он) төсвийн тэлсэн бодлого нь эдийн засгийн өсөлтийг сааруулдаг бол төсвийн алдагдал 10% нэмэгдэхэд ДНБ-ий өсөлт 3 нэгж хувиар буурч буйг харуулсан байна.
3. Засгийн газрын нийт өрийн 2015-2019 оны улирал бүрийн өөрчлөлтийг тооцоолж үзэхэд ДНБ-ий улирлын нэрлэсэн голч дүн 6740.1 тэрбум төгрөг, дундаж нь 7008.0 тэрбум төгрөг байгаа бол засгийн газрын нийт өрийн хуримтлагдсан дүн дунджаар 19299.1 тэрбум төгрөг, голч нь 21052.0 тэрбум, энэ хоёр үзүүлэлтийн харьцааны голч нь 312.3%, стандарт хэлбэлзлүүдийнх нь хоорондын харьцаа 246.9% байна. Зөвхөн эдгээр харьцаа төдийгүй өрийн тогтвортой байдлын үнэлгээний багц үзүүлэлтийн хувьд ч өрийн дарамт өндөр байгаа юм. Засгийн газрын нийт өрийн эргэн төлөлтийн голч нь 1917.4 тэрбум төгрөг, дундаж нь 2226.7 тэрбум төгрөг, экспортонд харьцуулснаар голч нь 54.1%, дундаж нь 63.5% байна. Өөрөөр хэлбэл, 2019 оны төсвийн гүйцэтгэл, засгийн газрын нийт өрийн эргэн төлөлтийн абсолют болон харьцангуй тоонууд хэдийгээр харьцангуй сайжирч байгаа ч **сүүлийн 5 жилийн дээрх тоонууд болон 2020–2022 оны төсөөллүүд, гадаад орчны эрсдэлүүд зэргээс харахад 2019 он болон 2020 оны эхний хагас жилийн хувьд төсөв болон засгийн газрын өрийн өөрчлөлтийн хувьд харьцангуй "амсхийх" хугацаа байгаа ч 2020 оны төгсгөлөөс байдал муудах эрсдэл бодитой оршиж байна.**
- 3.1. Хэдийгээр засгийн газрын өр, ДНБ-ий харьцааны босго хэмжээнээсээ доогуур (босго хэмжээ 70%, бодит хэмжээ 56% орчим) байгаа гэж Засгийн газар тооцож байгаа ч а. нэрлэсэн дүнгээр байгаа Засгийн газрын нийт өрийн хэмжээг ДНБ-д харьцуулсан үзүүлэлтийг өнөөгийн үнэ цэнээр тооцдог үзүүлэлттэй харьцуулж авч үзэж байх нь дүн шинжилгээний төдийгүй бодлогын хандлагын хувьд чухал юм. б. өрийн босго хэмжээний өнөөгийн мөрдөж буй 70% гэдэг бол эдийн засгийн нухацтай дүн шинжилгээний үр дүн гэхээсээ илүү улс төрийн хэлэлцүүлгийн үр дүнд гарч ирсэн тоо бөгөөд Монгол улсын хувьд хөгжлийн түвшний хувьд Европын холбооны гишүүн улсуудаас доогуур мөртлөө өрийн босго хэмжээг тэднээс доогуур тогтоож буй нь энгийн логикийн хувьд ч ойлгоход хүндрэлтэй юм.

VI. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

- 1. Боловсролгүй, хөдөлмөр эрхлээгүй эсвэл сургалтад хамрагдаагүй 15–24 насны залуучуудын тухайн насны хүн амд эзлэх хувь 2009–2018 онд 16–24.8% байгаа нь АНУ-ын "Rand" корпорацийн Монгол улсад хийсэн судалгаагаар тодорхойлсон "NEET" (not employed not educated, not trained) хэсгийн хувь өндөр байгааг, ажилгүйдлийн демограф бүтцийн энэ хэсгийг бодлогын хувьд онцгой анхаарахыг сануулж байна.**
- 2. Хөдөлмөрийн зах зээл дээр бодлогын хувьд онцгой анхаарвал зохих өөр нэг асуудал бол хөдөлмөрийн зах зээлийн албан болон албан бус хэсгийн харьцаа юм.** Монголбанкнаас хийсэн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дунд хийсэн судалгаанаас үзэхэд судалгаанд хамрагдсан 1320 иргэний 52% нь бизнесийн үйл ажиллагааг явуулах албан ёсны зөвшөөрөл, лиценз байхгүй үүнээс ердөө 8% нь зөвшөөрөл авахаар "хөөцөлдөж" байгаа гэсэн байв. **Үүний дээр уул уурхайн салбарын хууль бусаар ажиллаж буй "нинжа" гэж нэрлэсэн хэсэг, "бичил уул уурхай" эрхлэгчдийн асуудал, худалдаа, үйлчилгээ, барилга гэх мэт бусад салбарт ажиллаж буй албан бусаар хөдөлмөр эрхлэгчид, нийгэмд ямар нэг татвар төлдөггүй атлаа эдийн засгийн үйл ажиллагаа явуулж ашиг орлого олдог нийгмийн томоохон бүтэц болсон малчдын асуудал бол эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийн хөгжлийн тулгамдсан асуудал, эдийн засгийг албажуулах, ингэснээр ДНБ-ий тогтвортой, хүртээмжтэй чанарыг хангах гол чиглэлүүд юм.**
- 3. Үндэсний статистикийн хорооноос 2019 оны I улирлаас эхлэн Монгол улсын хувьд анх удаа хөдөлмөрийн дутуу ашиглалтыг (underemployment) хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний судалгаан дээр үндэслэн тооцож эхэлсэн нь цаашдаа хөдөлмөрийн зах зээл төдийгүй эдийн засаг, мөнгөний бодлогын судалгаанд чухал ач холбогдолтой болно.** 2019 оны эхний 3 улирлаар авч үзвэл хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 2019 оны I улиралд 18.7%, II улиралд 15.6%, III улиралд 14.2%, (Улаанбаатар хотод 20.3%, 17.0%, 16.4%), цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин 2019 оны I улиралд 14.2%, II улиралд 11.5%, III улиралд 10.7%, (Улаанбаатар хотод 15.6%, 13.2%, 12.7%) байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн хөгжлийн энэ асуудал дээр бодлогын (зөвхөн нэг яамны хүрээнд бус) онцгой анхаарал хандуулах шаардлага үүссэнийг харуулж

байна. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын асуудал бол бодлогын хувьд ажилгүйдэлтэй эн тэнцүү ач холбогдолтой асуудал бөгөөд хөдөлмөрийн бүтээмжийг бүх салбарын хувьд нэмэгдүүлэх томоохон эх сурвалж юм.

4. Бодит ДНБ-ий нэг ажиллагчид ногдох хэмжээний харьцангуй өөрчлөлт буюу хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийг 2005-2019 оны байдлаар авч үзэхэд 2005-2009 оны хооронд 2.6-9.1%, бодит цалингийн жилийн дундаж өсөлт 5.2-29.8%, 2010-2015 онд харгалзан -1.8-18.3% ба -0.5-24.1% байгаа бөгөөд ихэнх жил бүрийн хувьд дундаж цалингийн өсөлт түрүүлж байв. Төсөвт байгууллагын ажиллагчдын цалин 2016 онд 1888.1 тэрбум, 2017 онд 1947.9 тэрбум, 2018 онд 2047.8 тэрбум байсан бол 2019 онд 2471.0 тэрбум болж 20.7%-иар огцом өссөн байна. 2016-2019 оны байдлаар хөдөлмөрийн бүтээмжийн жилийн өсөлт -2-8.8%, дундаж цалин -2.7-5.7%, улирлуудаар авч үзвэл 2018 оны 4 улирал, 2019 оны эхний 3 улирлаас бусад жилийн улирлуудад дундаж цалингийн өсөлт ихэвчлэн түрүүлж байна. Энэ харьцаа гол салбаруудаар өөр өөр байгаа ч үндсэндээ хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт доогуур, дундаж цалин их төлөв түрүүлж өссөн хандлагатай байна.
5. Бизнесийн секторын хөдөлмөрийн бүтээмжийн 2005-2018 оны хандлагыг үзэхэд хэдийгээр гол салбаруудаар өөр өөр байгаа ч өсөлтийн хурдац нь мөн л доогуур, нэрлэсэн дундаж цалингийн өсөлтөөс ихээхэн доогуур байна.
6. Хөдөлмөр ба капиталын харьцаа буюу хөдөлмөрийн хөлс болон нийт ашиг, холимог орлогын харьцаа 2005-2019 оны хооронд орчлын мөчлөгийн үеийн хэлбэрүүдийг эс тооцвол үндсэндээ тогтвортой, 0.39-0.66 гэсэн харьцаатай, хөдөлмөрийн хөлс болон ДНБ-ий харьцаа 21-31%-ийн хооронд хэлбэлзэж байна.

VII. ӨРХИЙН ЭДИЙН ЗАСАГ

1. **Нэг өрхөд оногдох иргэдийн зээлийн үлдэгдлийг нэг өрхийн жилийн дундаж орлогод харьцуулсан үзүүлэлт 2010 онд 35.2% байсан бол сүүлийн 3 жилд, 2016 онд 57.7%, 2017 онд 61.3%, 2018 онд 70.1%, 2019 онд 60% болсон нь өрхийн орлого хангалттай хэмжээнд, зээлийн өсөлтөөс илүү ядаж тэнцүү хурдацтайгаар өсөх шаардлагатайг харуулж байна.** Нэг өрхөд оногдох иргэдийн хадгаламжийн үлдэгдэл зээлийнхээс абсолют хэмжээгээрээ их мэт боловч бодит амьдрал дээр нийт хадгаламжийн тархалтын тэгш бус

байдал маш өндөр, нийт хадгаламжийн ихэнхийг маш цөөхөн хүн эзэмшиж байгаа нь дээрх дүгнэлтийг баталж байна.

2. ЭЗССХ-ээс 2018 онд 3200 хүний дунд явуулсан түүвэр судалгааны үр дүнгээс тооцож гаргасан дундаж өрхийн тэнцлээр өрхийн аж байдлын цэвэр үзүүлэлт (net wealth) 33.9 сая төгрөг гарсан. Энэ болон бусад судалгааг цаашид гүнзгийрүүлэн Монгол улсын дундаж давхаргыг нарийвчлан тодорхойлж аж байдлын цэвэр үзүүлэлтийг гаргаж эдийн засгийн бодлогыг практикт нэвтрүүлэх нь чухал ач холбогдолтой. 2019 онд тус хүрээлэнгээс 2 дахь удаагаа 3000 илүү өрхүүдийн судалгааг хот, хөдөөгөөр хамруулан хийсэн бөгөөд доорх тоо баримт, дүгнэлтүүд гарсан болно. Үүнд:
 - 2.1. Судалгаанд 25-44 насны эрэгтэй, эмэгтэй, 3-6 ам бүлтэй өрхүүд түлхүү оролцсон байна. Тэдгээрийн 47% нь орон сууцанд амьдардаг, 16% нь орон сууцны зээл энд хамрагдаж сууцтай болсон, 9% нь түрээсийн байранд амьдарч байна.
 - 2.2. 32% нь банкны хадгаламжтай, ихэнх нь 3 сая төгрөг хүртэлх хадгаламжтай, хугацаа нь 3 жил хүртэл байна. Сарын дундаж орлого нь дунджаар 1.2 сая төгрөг, үүний дийлэхийг цалингийн орлого бүрдүүлдэг ба өрхийн орлого нь амьжиргаанд нь хүрэлцдэггүй гэж 50% орчим нь хариулсан байна. Сарын дундаж зарлага нь дунджаар 1 сая төгрөг, үүний ихэнх нь хүнсний бус зардал, зээлийн төлбөрт зарцуулагдаж байна.
3. Судалгаанд хамрагдагсдын **68% буюу 3 өрх тутмын 2 нь зээлтэй байна**. Зээлийг хэрэглээндээ зориулж ихэвчлэн банкнаас авдаг байна. Зээл авах болон зээлийн эргэн төлөх үйл явцын аль алинд нь хүү, хугацаа, хэмжээ хүндрэлтэй байдаг талаар онцолсон байна. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн **21% нь ипотекийн зээлд хамрагдсан, 74% нь хамрагдах хэрэгцээтэй байгаа** гэдгээ илэрхийлсэн ба гол бэрхшээлүүд нь өрхийн орлого үл хүрэлцэх, урьдчилсан төлбөр байхгүй, орон сууцны өндөр үнэ байна.
4. Судалгаанд хамрагдсан өрхүүдийг орлогын түвшингээр нь бага, дунд, өндөр гэж ангилан тэдний хөрөнгө болон зээлийн үзүүлэлтүүдийг ангилбал доорх байдалтай байна.

Хүснэгт 2. Өрхийн санхүүгийн цэвэр хөрөнгө (орлогын түвшингээр, сая төг)

Ангилал		Бага	Дунд	Дунджаас дээш
Нийт хөрөнгө		35.542	61.665	88.353
1.1	Биет хөрөнгө	34.872	59.615	82.613
1.1.1	Сууц	21817	40.761	54.527
1.1.2	Газар	3.775	4.648	5.493
1.1.3	Бусад үл хөдлөх хөрөнгө	2.850	3.724	8.807
1.1.4	Мал	3044,3	4.894	1.446
1.1.5	Тээврийн хэрэгсэл	2.672	4.705	10.126
1.1.6	Үнэт эдлэл	0.382	0.471	0.917
1.1.7	Бусад	0.331	0.411	1.298
1.2	Санхүүгийн хөрөнгө	0.669	2.051	5.739
1.2.1	Хадгаламж	0.541	1.790	4.389
1.2.2	Мөнгөн авлага	0.095	0.157	0.940
1.2.3	Хувьцаа	0.030	0.098	0.269
1.2.4	Бусад үл хөдлөх хөрөнгө	0.004 (3.822)	0.005 (4882)	0.140 (140.644)
Нийт зээл		8.633	13.737	20.315
2.1	Цалингийн	3.086	4.747	5.302
2.2	Бизнесийн	1.682	1.151	3.351
2.3	Тэтгэвэрийн	1.024	0.352	0.520
2.4	Хэрэглээний	0.171	0.209	0.336
2.5	Малчны	0.389	0.165	0.120
2.6	Автомашин	0.131	0.287	0.752
2.7	Кредит картны	0.069 (69.188)	1.136 (135.753)	0.188 (188.290)
2.8	Ипотекийн	1.844	5.376	8.050
2.9	Бусад	0.236	1.315	1.695
Цэвэр хөрөнгө		26.909	47.928	68.038

Эх сурвалж: Монголбанк, ЭЗССХ, өрхийн түүвэр судалгаа

- 4.1 Хүснэгтээс харахад нийт хөрөнгийн хувьд **бага орлоготой өрхүүдийн нийт хөрөнгө дундаас дээш орлоготой өрхийн нийт хөрөнгийн 40.2%, дунд орлоготой өрхүүдийн нийт хөрөнгийн 57.6%**-тай дүйцэж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр 3 орлогын бүлгийн харьцаа **0.58:0.70:1.00** дундаас дээш орлоготой харьцуулсан харьцаа **0.402:0.698:1.000** байна.
- 4.2 Биет хөрөнгийн бүлэг хоорондын харьцаа 0.585:0.722:1.000 түүний дотор сууцны хувьд 0.535:0.745:1.000, тээврийн хэрэгслийн хувьд 0.568:0.465:1.000 гэсэн харьцаатай байна.

- 4.3 Цэвэр хөрөнгө буюу нийт хөрөнгө нийт зээлийн зөрүү бага орлоготой бүлгийн хувьд 26.9 сая, дунд орлоготой бүлгийнх 47.9 сая, дундаас дээш орлоготой бүлгийнх 68 сая төгрөг байгаа бөгөөд **цэвэр хөрөнгийн бүлэг хоорондын харьцаа 0.561:0.704:1.000, дундаас дээш орлогын бүлэгтэй харьцуулснаар 0.395:0.704:1.000 болж байна.**
5. Хэдийгээр энэхүү түүвэр судалгааны үр дүнгээр олон улсын хэмжээнд өргөн хэрэглэгддэг өрхийн нэг хүнд оногдох орлого 10-50 долларын хооронд байдаг өрхүүдийг дундаж давхаргад хамруулж үздэг арга зүйгээр тооцож **үзэхэд нийт өрхийн 53% нь дундаж давхаргад хамрагдаж байгаа ч дараах зүйлүүдийг дараагийн судалгаагаар тодруулах шаардлагатай.**
- Түүвэрлэлтийг төлөөлөх чадвар, арга зүйн хувьд сайжруулах
 - Бага, дунд, өндөр (энэ бол харьцангуй ойлголтоос гадна өндөр орлоготой бүлгийн өрхүүд иймэрхүү судалгаанд хамрагдах хүсэл сонирхол бага байдгийг харгалзан дундаас дээш гэж нэрлэх нь зүйтэй.) гэсэн ангиллыг орлого, зарлагынх нь хувьд тодорхой тоогоор илэрхийлэх, өрхийн хүнсний зарлагын нийт зарлагад эзлэх хувийн жин хоорондын ялгаа бага, 30%-аас дээш гарахгүй байгааг онцгой анхаарах.
 - Орлогын бүлэг бүрээр гаргасан хадгаламжийн хэмжээний интервалыг харахад "өндөр" орлоготой бүлгийн 3 сая хүртэлх төгрөгийн хадгаламж 40%, нөгөө 2 бүлгийн хувьд бараг ялгаагүй, 59-61% байгаа нь эргэлзээ төрүүлж байна. Өрхийн зарлагад хүнсний зүйлийн зарлагын эзлэх хувь хэмжээ орлогын бүлгүүдийн хоорондын ялгааг тодорхой харуулдаг үзүүлэлт байхад Монголын нөхцөлд энэ 3 бүлгийн хувьд уг үзүүлэлт 25%, 22%, 21% байгаа нь эргэлзээтэй байна.
6. Нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ төлдөг 580369 хүний (2019 оны эхний хагас жилийн байдлаар) **14.4% буюу 83537 хүн 301-500 мянган төгрөгийн цалингийн бүлэгт харьяалагдаж гар дээрээ дунджаар 275-430 мянган төгрөг авч байна. Бага цалинтай эдгээр хүмүүсийн хүнсний хэрэглээ 40%-иас дээш байдаг нь судалгаагаар тогтоогдсон бөгөөд энэ хүмүүсийн хувьд инфляци, түүний дотор хүнсний инфляци (10.8% байгаа) өрхийн худалдан авах чадварт нь хамгийн их сөргөөр нөлөөлөх юм.**

- 6.1. **501–700 мянган төгрөгийн цалинтай, гар дээрээ дунджаар 540 мянган төгрөг авдаг 108827 хүн байна. (18.2%) Энэ 2 бүлгийн нийлбэр хувь 32.6% байна. 700–900 мянган төгрөгийн цалин авдаг 100938 хүн (17.4%) байгаа бөгөөд эдгээрийн гар дээрээ авдаг цалин дунджаар 615 мянган орчим, сарын хэрэглээ нь 280 мянган төгрөгөөс дээш, хүнсний хэрэглээ нь 30%-иас дээш байхаар байна. Өөрөөр хэлбэл, 580.4 мянган хүний 50%-ийн хүнсний хэрэглээ дунджаар 40% байхаар байна.**
- 6.2. 900-1100 мянган төгрөгийн цалин авдаг 86578 хүн (14.9%), 1101-1300 мянган төгрөгийн цалин авдаг 57618 хүн (9.9%), энэ 2 бүлэг дээр 700-900 мянган төгрөг авдаг 100938 (17.4%) хүн нэмэгдвэл **42.2% болж байгаа** бөгөөд энэ нь Монголын нийгмийн давхраажилтийг цалингийн орлогоор тооцсоны гол бүрэлдвэр хэсэг буюу **дунджаас доош давхарга** болно.
- 6.3. **Дундаж давхаргад хамаарах хэсэг нь 1301–1500 мянган төгрөгийн цалинтай 3551 хүн (6.1%), 1501–2500 мянган төгрөгийн цалинтай 69308 хүн (11.9%), 2501–3500 мянган төгрөгийн цалинтай 20354 хүн (3.5%) нийлээд 21.5% болж байгаа нь дундаж давхарга гэж үзэж болох бөгөөд үүн дээр 3501–5000 мянган төгрөг авдаг 17658 хүн (3%)–ийг нэмбэл 24.5% болж байна.** Энэ тоо бол бага бөгөөд нийгмийн өнгө төрхийг тодорхойлдог, нийгмээ "чирч явдаг цөм сүрэг" болдог дундаж давхаргын хувь хэмжээ ийм бага байгаа нь Монгол улсад төрийн бодлогын гол тэргүүлэх чиглэл хаашаа чиглэхийг маш тодорхой зааж буй бодит жишээ юм (11 жилийн дараа буюу 2030 онд "чинээлэг, дундаж анги" нийгмийн страта бүтцийн зонхилох хэсэг болно гэж зорилт тавьсан улсын хувьд). **Эндээс ХҮИ-ийг тооцох, өрхийн орлого, зарлагын түүвэр судалгаа хүнсний хэрэглээ нь 30% ба түүнээс доош 30%–40%, 40% ба түүнээс дээш өрхийн бүлгүүдээр тооцож гаргадаг болох нь инфляцыийг онилох бодлогын зорилтыг илүү "байндаа тусдаг" болгох ач холбогдолтой болно.**
7. Мал – хөрөнгөө эдийн засгийн эргэлтэд оруулж түүнээсээ гол орлогоо олж байдаг, "нийтийн өмчийн эмгэнэл" ("tragedy of commons")-ийн гол тусгал болж байдаг нийгмийн энэ томоохон бүлгийн давхраажилтын үйл явцыг тооцсоноор Монголын нийгмийн давхраажилтын бүтэц, орлогын тэгш бус байдлын бүрэн зураглалыг гаргах боломжтой. Өнгөрсөн 20-оод жилийн үйл **явцын үр дүнд өнөөгийн байдлаар**

200 хүртэлх толгой мал бүхий малчин өрхүүд нийт малтай, малчин өрхүүдийн (статистикийн практикт малтай ба малчин өрхүүд гэж ангилдаг) 57% орчим (энэ тоог 2016 онд гаргасан, 2018 оны мал тооллогын үр дүнгээр шинэчлэн гаргаж болно), нийт малын тоо толгойны 75% орчмыг эзэмшиж байгаа. Мал – хөрөнгөөр нь натурал тоо ашиглан тооцвол ийм тоо гардаг бөгөөд энэ нь сүүлийн 20 гаруй жилд орлого, хөрөнгийн тэгш бус байдлыг бодитой илэрхийлж чадах баримт юм. **200–400 толгой малчид дундаж давхаргын суурь болж байна гэж үзэж болохоор байгаа бөгөөд энэ бүлэглэлт дээшлэх тусам хөрөнгийн тэгш бус байдлын ялгавар нэмэгдэх, хамгийн их толгой малтай малчин өрхүүд болон хамгийн бага толгой малтай малчин өрхүүдийн боломжит орлогын ялгаа нь хэрэглээгээр нь тооцоноос эрс өөр үр дүн үзүүлдэг.** Зөвхөн малын тоо толгойг нь авч зах зээлийн үнэлгээнд шилжүүлснээр мал – хөрөнгийн мөнгөн илэрхийлэлд шилжүүлж, малчны нэг өрхөд оногдох зээл, хадгаламж гэх мэтийг нь нэмж тооцоолон малчны аж байдал, амьжиргааг нь тодорхойлж татварын тогтолцоонд хамруулах нь татварын шударга байдлын зарчим төдийгүй нийгмийн шударга ёсны асуудал юм.

8. Хотын өрхүүдийн хувьд нийгмийн страта бүтцийг нь илүү зөв гаргахад тус дөхөм болох нэг гол хөрөнгийн үзүүлэлт бол тэдний эдэлж хэрэглэж буй машин, орон сууц юм. Улсын дүнгээр техникийн үзлэгт хамрагдсан машины тоог 2018 оны байдлаар ангилсан статистикийг харахад нийт 584.4 мянга байгаа бөгөөд (2010 онд 254.5 мянга) 3 хүртэл жилийн насжилттай нь 2%, 4-9 жилийн насжилттай нь 20.6% (2010 онд 21.3%), 10-аас дээш жилийн насжилттай нь 77.4% (75.3%) байгаа нь **машинтай өрхүүдийн ихэнх нь хуучин машин хэрэглэж буйг харуулах баримт** юм. Хүн ам, орон сууцны 2015 оны тооллогоор 859.1 мянган өрхийн 45.5% нь гэрт, 54.2% нь байшинд амьдарч байгаа бөгөөд **байшинд амьдардаг 465.3 мянган өрхийн 43.9 мянга нь (9.4%) 20м.кв хүртэл, 21–30 м.кв-д 99.0 мянга (21.3%), 31–40 м.кв-д 91.5 мянга (19.7%) өрх буюу 41% нь 21–40 м.кв орон сууцанд амьдарч байна. 41–60 м.кв –д 52 мянган өрх (11.2%), 81 м.кв-аас дээш 43.1 мянган өрх (9.3%) амьдарч байв.** Өөрөөр хэлбэл, орон сууцыг мкв-аар бүлэглэвэл 20 хүртэл болон 21-30кв-д 142.9 мянган өрх (30.7%), 31-60мкв 227.2 мянган өрх (48.9%), 61-81+мкв-д 95.1 мянган өрх (20.5%) байгаа нь дундаж давхаргыг тодорхойлоход арга зүйн ач холбогдолтой юм. Орон сууцны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдал, хүн амын орлогын түвшин, демограф бүтэц, ипотекийн зээлийн тогтолцооны

тархалт, орон сууцанд хамрагдах боломжийн түвшин (affordability) зэргийг харьцуулаад үзэхэд 2020 оны ээлжит тооллогоор энэ дүр зураг үндсэндээ хадгалагдахаар байна. Иргэдийн дундаж өр болон орлогын харьцаа цалингийн зээл дээр 64%, тэтгэврийн зээл 84% (!), хэрэглээнийх 66%, нийт дүнгээрээ 69% байгааг (Монголбанкны 2018 оны судалгаагаар) дээр нь нэмж тооцвол **иргэд, өрхүүдийн амьжиргааны түвшин, давхраажилтын бүтэц, дундаж давхаргын хувь хэмжээг нэмэгдүүлэх асуудал нь өнөөдрийн Монголын нийгмийн хамгийн тулгамдсан асуудал болсон байна гэсэн дүгнэлт хийж болно.**

- Тэтгэврийн зээлийг тэглэх талаар УИХ хууль гаргасан болон Засгийн газрын эдийн засаг, төсөв хариуцсан яамны шууд оролцоогүйгээр төсвөөс гадуур бодлого хэрэгжүүлсэн нь ОУВС-ийн зүгээс ирэх хариу үйлдлийг анхаараагүй, сонгуульд зориулсан улс төрийн шийдэл, алхам бөгөөд 2020 оны эдийн засгийн бодлогод сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.

VIII. БИЗНЕСИЙН ЭДИЙН ЗАСАГ

1. Үндэсний статистикийн хорооны бизнесийн санд 2018 оны эцсийн байдлаар нийт 170.2 мянган хуулийн этгээд бүртгэгдсэний 126.4 мянга нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. 170.2 мянган хуулийн этгээдийн 50.4% үйл ажиллагаагаа явуулж 49.6 нь тодорхой шалтгаануудаар үйл ажиллагаа явуулаагүй байна. **Ийм хандлага сүүлийн 20 гаруй жилд хадгалагдаж байгаа нь бизнесийн орчлын реформ тууштай хийгдэж ирээгүй, бизнесийн санхүүжилтийн хүртээмжтэй орчин, арга хэрэгслүүд сайн хөгжөөгүйтэй холбоотой.**
2. Үйл ажиллагаа хэвийн явуулж буй хуулийн этгээдүүдийн тооны хувьд нэмэгдэж буй хэдий ч (тухайлбал, 2013 онд 54.9 мянга, 2018 онд 85.7 мянга) **чанарын хувьд дорвитой өөрчлөлт гараагүй, ихэнх нь худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлсэн хэвээр байна. (2013 онд 43.2 мянга, 2018 онд 67.9 мянга)**
3. Үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээд 2015 онд 62.2 мянга байсан бол 2016 онд 69.3 мянга, 2017 онд 76.5 мянга, 2018 онд 84.4 болж өссөн ба шалтгаанаар нь авч үзвэл **“үйл ажиллагаа эхлээгүй” гэдэг шалтгаанаар 2015 онд 21.1 мянга (33.9%), 2016 онд 30.5 мянга (44.1%), 2017 онд 38.1 мянга (49.9%), 2018 онд 44.5 мянга (52.7%) болж жил бүр өсөж ирсэн байна. Харин “үйл ажиллагаагаа түр зогсоосон”**

гэсэн шалтгааны эзлэх хувь хэмжээ энэ хугацаанд харьцангуй буурч "үйл ажиллагаа бүрэн зогссон" гэсэн шалтгаантай хуулийн этгээдүүдийн тоо харьцангуй тогтвортой байна. (2.1-2.6%)

4. Ажиллагчдын тооны бүлгээр ангилсан үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн хувьд 2018 оны байдлаар нийт 85.7 мянган хуулийн этгээдийн 86.2% нь 1-9 ажиллагчтай, 6% нь 10-19, 4.9% нь 20-49, 2.9% нь 50 ба түүнээс дээш ажиллагчидтай байгаа нь сүүлийн 4 жилд харьцангуй тогтвортой байгаа хандлага юм.
5. Ажиллагчдын тооны бүлгээр авч үзвэл 2016 онд 72.2 мянган этгээд 680.1 мянган ажиллагчидтай байсан бол 2018 онд 85.7 мянган этгээд 758.8 мянган ажиллагчидтай, 2018 оны эцсээр үйл ажиллагаа явуулж буй 71.5 мянган хуулийн этгээд аж ахуйн нэгж 69.8 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн байна.
6. Үйл ажиллагаа явуулсан аж ахуй нэгжийн борлуулалтын орлого 2015 онд 36.6 их наяд, 2016 онд 42.4 их наяд, 2017 онд 52.5 их наяд, 2018 онд 69.8 их наяд байна. 2018 оны борлуулалтын орлогын 43.9 их наяд буюу 62.9%-ийг Монгол улсын иргэний хувийн өмчийн аж ахуй нэгжүүд, 13.2%-ийг гадаад улсын аж ахуй нэгжүүд (9.2 их наяд), 12.3%-ийг (8.6 их наяд) төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуй нэгжүүд, 11.6%-ийг (8.1 их наяд) гадаадтай хамтарсан аж ахуй нэгжүүд бүрдүүлж байна.
7. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн тоо 2014 онд 41.7 мянга (нийт аж ахуй нэгжийн 67.9%), 2015 онд 43.7 мянга (68%), 2016 онд 49.1 мянга (68%), 2017 онд 53.5 мянга (68.1%), 2018 онд 58.5 мянга (68.3%) болж өссөн бөгөөд 67.5% нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа эрхэлж байна. 2018 оны байдлаар салбарын ангиллаар нь хувааж үзвэл 5.9% нь хөдөө аж ахуйд, 8.8% нь аж үйлдвэр, барилга 10.3%, бөөний худалдаа 32.2%, жижиглэн худалдаа 18.9%, үйлчилгээ 23.8% байна.
8. Борлуулалтын орлогын бүлэглэлээр нь авч үзвэл 2018 онд 300 сая төгрөг хүртлэх борлуулалтын орлоготой 52 мянга, 300 сая-1 тэрбум 4.6 мянга, 1.0-2.5 тэрбум орлоготой 1.9 мянга байна. Бизнес регистрийн санд 2018 онд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагад 758.8 мянган ажиллагчид ажиллаж байгаагийн 208.9 мянга буюу 27.5% нь ЖДҮҮ эрхлэгчид байна.
9. ЖДҮҮ эрхлэгчдийн борлуулалтын орлого 2018 оны байдлаар 1-2.5 тэрбум борлуулалтын ангиллаар 2967.3 их наяд (нийт аж ахуй нэгжийн

борлуулалтын орлого 3713.6 их наяд), 300 саяас 1 тэрбум ангилал 2574.9 их наяд (3115.9), 300 сая хүртэл 1773.8 их наяд (2091.1) гэсэн байдалтай байна.

10. Бизнесийн секторын гүнзгийрүүлсэн лүн шинжилгээг цаашдаа Монголбанк, ҮСХороо хамтран үндэсний тооцооны бизнесийн секторын дансаар болон үйлдвэрлэлийн салбаруудаар хийж нийт ашиг, холимог орлого, бизнесийн секторын нийт эдийн засгийн гол үзүүлэлтүүдтэй харьцуулсан үзүүлэлтүүд, хөрөнгө оруулагчийн болон ашгийн харьцаа (ашгийн маржин), хуримтлалын харьцаа, бизнесийн секторын эзэмшлийн нийт орлого, татварын ачаалал зэрэг үзүүлэлтийг жил бүр гаргаж байх нь чухал юм.
11. Санхүүгийн бус секторын (бизнесийн секторын) үйл ажиллагааны ашиг 2011-2018 онд жилд дунджаар 14.4% өссөн ч энэ үзүүлэлтийн нийт (нэмэгдэл өртөгт эзлэх хувь) 2016 он хүртэл буурч байснаа 2017 онд 66.1%, 2018 онд 65.8% байна. Хөрөнгө оруулалтын түвшин 2012-2016 онд үндсэн хөрөнгийн хуримтлал (үндсэн капиталын бүрдэлд) эрчимтэй буурсны үр дагавар болж 2012-2016 онд 79.6%-аас 28% болж буурсан ба 2017 30.6%, 2018 онд 42.6% болсон байна.

“Өндөржүүлсэн бэлэн байдлын” үеийн эдийн засгийн бодлого

2 сарын 13-аас хойш Монгол улс “өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн” (хэсэгчилсэн) дэглэмд шилжсэн. Өнөөдрөөс эхлэн 4 сар болтол сунгав. Гамшгийн үеийн тухай хуулинд:

- 10.1.1. Өдөр тутмын бэлэн байдал
- 10.1.2. Өндөржүүлсэн бэлэн байдал
- 10.1.3. Бүх нийтийн бэлэн байдал

гэж ангилсан байдаг байна. Ийм байдлын үед дараах арга хэмжээг авна гэж заасан байна. Үүнд:

10.4.1. Гамшгийн зарлан мэдээллийн дохиог хүн амд хүргэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжүүлэх (Эрүүл мэндийн яамнаас өдөр бүр мэдээлэл хийж, телевиз, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр корона вирусийн хор хөнөөл, тархалт, урьдчилан сэргийлэх талаар хангалттай мэдээлэл гарч байгаа.)

- 10.4.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон орон нутгийн

захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх; (УИХ энэ тусгай горимд хамааралгүй бололтой; “чуулган завсарласан”)

10.4.3. Гамшгийн зарлан мэдээллийг хүн амд шуурхай, хүртээмжтэй хүргэх; (Онцгой байдлын ажлын хэсэг өглөө бүр хүргэж байгаа.)

10.4.4. Хорио цээрийн дэглэм тогтоох, хүч хэрэгсэл, гамшгийн болон орон нутгийн нөөцийг дайчлах; (Улаанбаатар хот, бүх аймаг тодорхой цаг хугацаанд хүмүүс, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт хийж байгаа.)

10.4.5. Гамшгийн нөөцийг улсын хэмжээнд Засгийн газрын шийдвэрээр, орон нутагт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр нэмэгдүүлж ажиллана. (“гамшгийн нөөц” гэсэн ойлголтыг хуулиндаа тодорхой заасан байх, бодвол бараа, хүнс, хүн хүч, санхүүгийн нөөцийг хамруулсан байх гэж найдаж байна...)

Улаанбаатар хот үүнээс бүр өмнө 2019 оны 10 сарын 1-ээс 2020 оны 4-р сарын 1 хүртэл Улаанбаатар хотын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллах шийдвэр гаргаад хэрэгжүүлж байгаа юм байна. Бүх аймагт мөн л ийм байдлаар шийдвэр гарсан байна. Гэхдээ үндэсний болон аймаг, хотын түвшинд гарсан эдгээр шийдвэрийн алинд ч эдийн засгийг яаж зохицуулах талаар тодорхой чиглэл, бодлого алга.

Тэгвэл “өндөржүүлсэн бэлэн байдлын” үед эдийн засаг яадаг вэ?

Мэдээж хэрэг зах зээлийн хариу урвал, хариу үйлдэл илүү шуурхай, уян хатан байж чаддаг болохоор компаниуд, эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэгч хувь хүмүүс, хэрэглэгчид өөр өөрсдийнхөөрөө “өндөржүүлсэн бэлэн байдалд” орох, дасан зохицох хариу үйлдлүүд хийх нь тодорхой. Эдгээр хариу үйлдэл нь эерэг ч сөрөг ч үр дагавартай байж болно, иймээс сөргийг нь хамгийн бага хэмжээнд эерэгийг нь хамгийн их байхаар зохицуулах төрийн бодлого гэж байх ёстой. Эсрэгээр нь биш.

Дээр дурдсанаар “Гамшгийн үеийн хууль” болон бусад хуульд энэ талаар байхгүй. Тиймээс энэ нь тухайн үеийн Засгийн газар, УИХ-ын гамшгийн үеийн бодлогын мэдрэмж, хурдац, үр дүн, үр ашигтай бодлого төлөвлөж хэрэгжүүлэх чадвараас шууд хамаарна. Одоогоор Монгол улсад “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн үед эдийн засгийн удирдах, болзошгүй хямралаас урьдчилсан сэргийлэх тухай” Засгийн газрын ямар нэг бодлого, шийдвэр, тогтоол гараагүй (2050 оны “Алсын хараа” гэсэн баримт бичгийг л бие биедээ гардуулаад байх шиг байсан), УИХ нь завсарласан, “амарч байгаа”, ээлжит бус чуулган зарлан хуралдуулж дээрх асуудлыг хэлэлцэх тухай ямар нэг мэдээлэл гараагүй л байгааг бодоход тийм ч өндөр “өндөржүүлсэн бэлэн байдал” биш бололтой... Гэтэл гадаад орчинд болохоор өөр хандлагатай; БНХАУ төдийгүй

дэлхийн бусад улсууд эдийн засгийн өсөлтийн төсөөллүүддээ яаралтай засвар оруулж гарцаагүй болсон бууралтын мөчлөг (recession), болзошгүй хямралаас урьдчилан сэргийлсэн бодлогын арга хэмжээнүүд, хариу үйлдлүүдийг шат дараалан авч эхэлж байна. Бизнесийн орчлын үргэлжилж ирсэн түүхэн хугацаанаас харсан ч бууралтын мөчлөгийн талаар корона вирус гарахаас ч өмнө мөчлөг глобал түвшинд эхлэх гэж буй талаар олон улсын байгууллагууд, эдийн засагчид ярьж бичиж байсан бөгөөд корона вирусын тархалт, хурдац энэхүү үйл явцыг хурдасгагч, өдөөгч болж байна. Гадаад орчны байдал иймэрхүү байдалтай өрнөж байгаа, эдийн засаг, худалдааны гол түнш маань болох Хятадын эдийн засаг бууралтын мөчлөгөөр хязгаарлагдахгүй глобал эдийн засгийн хямралын дохио болж буй ийм үед Монгол улс эдийн засгийн бодлогын хувьд бараг “зүгээрийг хийгээд” сууж боломгүй, ийм “өндөржүүлсэн бэлэн байдалд” байж таарахгүй. Төр өөрөө паник үүсгэхгүй, өдөөхгүй, эрүүл мэнд, эдийн засгийн бодлогодоо эн тэнцүү ач холбогдол өгч зах зээл, эдийн засгийн хэвийн үйл ажиллагааг хангахад л “өндөржүүлсэн бэлэн байдлын” үеийн эдийн засгийн бодлогын гол агуулга байх учиртай. Төр нь “маанагтвал” түмэн олон нь дагаад л паникдана.

Хүн төрөлхтний өнөө хүртэл даван туулж ирсэн эдийн засгийн хямрал, бууралтуудыг түүхэнд тэмдэглэгдсэн байдлыг үзэхэд хоёр үгээр хамгийн их илэрхийлэгдсэн байдаг: panic (үймээ, сандрал, хөөрөл), depression (сэтгэл санааны гутрал, уналт, унжгар байдал гэх мэт).

Дээрх хоёр үг санаандгүй зүйл огт биш бөгөөд зах зээлийн оролцогчдын сэтгэл санаа, хүлээлт, авир төрхийн илэрхийлэл болж эдийн засаг, зах зээлийн үйл явцад шууд нөлөөлж хямралын шалтгаан үр дагаврын илэрхийлэл болдог тул түүхэнд ийнхүү тэмдэглэгдсэн байна. Тийм ч учраас зах зээл дээр panic, depression үүсгэхгүй байх нь аливаа хямралын үед зайлшгүй чухал тул олон орны засгийн газрууд хариу үйлдлээ цаг алдалгүй хийж эдийн засгаа хэвийн гольдролд нь байлгах, бууралт, уналтыг зөөлөвчлөх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхлээд байна. Тиймээс **Монгол улсын хувьд бууралтын үед эдийн засгаа идэвхжүүлэх, болзошгүй хямралаас сэргийлэх зорилгоор УИХ-ын ээлжит бус чуулганы зарлан хуралдуулж үүсээд буй эдийн засгийн нөхцөл байдлыг авч хэлэлцэн Засгийн газарт тодорхой чиглэлүүд өгсөн тогтоол гаргах, Засгийн газрын хувьд хувийн хэвшилтэй хамтран эдийн засгийг идэвхжүүлэх, болзошгүй хямралаас сэргийлэх онцгой байдлын төлөвлөгөө (emergency plan) гаргаж хэрэгжүүлэх нь чухал.** Энэхүү тогтоол, төлөвлөгөөнд доорх зүйлүүдийг багтаах хэрэгтэй. Үүнд:

1. Эдийн засгийн өсөлтийг хадгалж чаддаггүй юм гэхэд бууралтын эрчийг

сааруулах;

- 2019 оны III улирал, эхний 3 улирлын эдийн засгийн өсөлтийн улирлаас улирлын жилд шилжүүлсэн өсөлт (улирлын нөлөөллийг хассан) бараг (-) дүнтэй буюу өсөлтгүй гарсан нь 2016 онд гарч байсантай ижилхэн байсан. Тиймээс 2019 оны дүнгээр жилийн өсөлт бууралттай ч эерэг байна гэсэн төсөөлөл, үнэлгээгээр өөрсдийгөө хуурах хэрэггүй.
- 2019 оны IV улирлын хувьд улирлаас улирлын өсөлт нь 0.3%, жилд шилжүүлсэн өсөлт нь 1.7% байгаа гэдгээр цаашдын өсөлтийн бодлогын баримжаа, чиглэлээ авах хэрэгтэй. 2020 оны эхний улирлын өсөлт (-) тэмдэгтэй гарах нь өндөр магадлалтай болсон, 2020 оны дараагийн улирлуудад ч ийм байдал хадгалагдахаар байна.
- Эдийн засгийн өсөлтийг хангах гадаад эрэлт (экспорт, ГШХО) эрс буурсан нөхцөлд өсөлтийг хангах дотоод эрэлтийг идэвхжүүлэх замаар өсөлтийг бууруулахгүй байх бүхий л сувгийг ашиглах (бизнес хөрөнгө оруулалтын орчныг нэмэлт зохицуулалтаар дарамталж муутгахгүй байх, саад болж буй захиргааны зохицуулалтууд, дүрэм журмыг эрс багасгах, татвар, гааль, хилийн хяналт шалгалтыг “өндөржүүлсэн бэлэн байдлаар” гулд барьж чангатгахгүй байх гэх мэт.)
- Эдийн засгийн нийлүүлэлтийн тал дээр аль болох чөлөөтэй байлгах, корона вирус илрээгүй зах зээл, тухайлбал, ОХУ-ын зах зээл дээр идэвхтэй ажиллах гарц, боломжуудыг бизнес эрхлэгчдэд нээж өгөх.
- Мал аж ахуй, үйлчилгээний сектор гэх мэт салбаруудын нийлүүлэлтийн хэлхээ сувгуудад тасалдал үүсгэхгүй байх.
- Уул уурхайн секторт төрийн өмчийн давамгайлал үүсгэх, “нөөцийн үндэсний үзлийг” дэвэргэх, хувийн хэвшлийн хайгуул болон олборлолтын лицензийн “замбараагүй байдлыг” цэгцэлсэн бол одоо хэвийн үйл ажиллагааг нь хангаж, үйл ажиллагааг нь идэвхжүүл. Зах зээлийн эрэлт нь унасан ч боломжтой хэлбэрээр хайгуул, олборлолтын үйл ажиллагаагаа явуулж бизнесийн хэвийн үйл ажиллагаагаа сэргээг.

2. Хэрэглээний зах зээл дээр аливаа нэг паник үүсэх, үүсгэхээс сэргийлж

бараа, үйлчилгээний нийлүүлэлтийг хиймлээр тасалдуулах, тодорхой барааны зах зээл дээр хиймэл хомстол үүсэхээс сэргийлэх.

- Өргөн хэрэглээний бараанууд, тухайлбал, цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тос гэх мэт бүтээгдэхүүний хил гаалийн хяналт шалгалтыг хөнгөвчлөх, барааны эргэлтэд саад тотгор учруулж буй хяналт шалгалтын дэг журмыг сулруулж эргэлтийг түргэсгэх, хүүхдийн болон насанд хүрэгчдийн дархлааг дэмжих, сайжруулах бэлдмэл, эм зэргийг Япон, Герман гэх мэт хөгжилтэй улсуудаас оруулж ирэх импортын сувгийг чөлөөтэй болгох, өргөн хэрэглээний болон эрүүл мэндийн зориулалттай зарим барааг татвараас чөлөөлөх.
 - Төмс, хүнсний ногоо, гурил, цагаан будаа, улаан буудай гэх мэт бүтээгдэхүүний зах зээлийн нөөц хамгийн ихээр бодоход нэг сарын нөөц түүнээс бага байгаа. Нөөц хомстод зах зээлийн хэвийн үйл ажиллагаа доголдоод ирвэл инфляци гэдэг “вирус” идэвхжиж хүн амын худалдан авах чадварыг “устгаж” энэ нь зах зээлд эргээд нөлөөлдөг “гинжин урвал” бодитойгоор үүсэх эрсдэл “өндөр” зэрэглэлд байна. Энэ бол “өндөржүүлсэн бэлэн байдлын” үнэлгээний нэг гол эрсдэл юм. (Харамсалтай нь ийм эрсдэлийн үнэлгээ хийгдэхгүй байна.)
 - Махны дотоод нийлүүлэлтийн суваг, гурилын дотоод болон импортын суваг дээр онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Хот, хөдөөгийн хоорондох махны нийлүүлэлтийг аль болох идэвхжүүлэх, хүмүүс хот руу ирж мах нийлүүлэх үйл явцад ямар нэг хиймэл саад, хориг тавих хэрэггүй бөгөөд “өндөржүүлсэн бэлэн байдлыг” эдийн засгийн үр дагавар талаас нь сайтар харгалзсан, хот, хөдөөгийн эдийн засаг, бизнесийн хэвийн хэлхээ холбоог аль болох тасалдуулахгүй байх, хэрэглээний зах зээл дээр махны үнэ огцом өсөх, паник үүсэх байдлаас онцгой сэргийлэх нь чухал. Махны үйлдвэрүүдийн махны нөөц дунджаар 10 хоногийн нөөцтэй байгаа үед хот, хөдөөгийн хооронд явагдаж буй махны нийлүүлэлтийн үйл явцыг “өндөржүүлсэн бэлэн байдлын” захиргааны арга хэрэгслээр тасалдуулбал “хомстол, паник, инфляц” гэсэн 3 үгээр эдийн засгийн “хариу” барина. Гурилын импортыг чөлөөтэй болгох, ямарваа нэг квот, “үндэсний үйлдвэрлэл” хамгаалсан зохицуулалтаас тодорхой хугацаанд татгалзах нь чухал.
3. Аж үйлдвэр, барилга гэх мэт бодит секторын бусад салбарт идэвхжлийг нэмэгдүүлэх бодлогын болон санхүүжилтийн орчныг сайжруулах чиглэлээр УИХ-аас тодорхой чиглэлүүд гаргавал зохино. Тухайлбал, жижиг, дунд бизнесийнхэн бизнесийн үйл

ажиллагааг идэвхжүүлэх, санхүүжилтийн сувгийг өргөтгөх, бизнест шинээр орох, бизнесийн үйл ажиллагаагаа эхлүүлэх гэх мэт гарааны үе, орчин, санхүүжилтийн механизмыг сайжруулах чиглэлээр тодорхой чиглэлүүд гаргах нь чухал.

4. Гадаад худалдааны дэглэмийг илүү чөлөөтэй болгож өнөөгийн дэглэмийн үед шаардагдаж буй бичиг баримтуудыг эрс багасгах шаардлагатай бөгөөд Монгол шиг жижиг эдийн засагтай улс нээлттэй байдлын зэрэглэлээ дээшлүүлж байж л эдийн засгийн бууралт, хямралыг зөөллөж чадах бөгөөд гадаад худалдааг хорих, хязгаарлалт хийхээсээ илүү гадаад худалдааны газар зүйн чиглэлийг өөрчлөх, өөрөөр хэлбэл, корона вирусгүй бус нутаг, зах зээл рүү шилжүүлэх чиглэлээр эдийн засгийн дипломат үйл ажиллагаа, хүчин чармайлт гаргах нь чухал. Тухайлбал, уул уурхайн бус экспортыг ОХУ-ын зах зээлд гаргах хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх, тодорхой бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний бүлгээр ангилсан, хувийн хэвшлийн шууд оролцоотой, санхүүжилтийн тодорхой тогтолцоо бүхий зорилтот зах зээлийн хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй. Герман, Польш гэх мэт Европын улсуудаас бараа оруулж ирэх сувгийг дэмжиж Гадаад хэргийн яам ядахдаа виз авах үйл ажиллагааг хөнгөвчлөх, шуурхай болгох чиглэлээр ажиллавал зохино. МИАТ, төмөр зам, тээвэр зуучийн компаниудын үйл ажиллагааг энэ зорилтод чиглүүлж уялдуулсан, нэгдсэн бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй.
5. Үүсээд буй нөхцөл байдал бол “force majeure” “давагдашгүй хүчин зүйлийн” нөхцөл байдал юм. “Өндөржүүлсэн бэлэн байдал” гэдэг нь угтаа төр үүнийг хүлээн зөвшөөрч буй хэрэг. Гэхдээ олон улсын практикт “давагдашгүй хүчин зүйлийн” тодорхойлолтыг Засгийн газар, төр бус, түүнээс хараат бус хөндлөнгийн байгууллага тодорхойлдог. Монгол улсын хуулиар МҮХАҮТ давагдашгүй хүчин зүйлийн тодорхойлолтыг гаргах хуулиар тогтоосон цорын ганц субъект юм. Тиймээс энэ байгууллага тодорхойлсон бол (2009 оны хямралын үед МҮХАҮТ яг ийм байдлаар ажиллаж байв.) түүнтэй холбогдсон гэрээний эрх зүйн бүх заалтууд гадаад, дотоодод хүчин төгөлдөр хэрэгжих учиртай. МҮХАҮТ энэ чиглэлээр ажиллаж аж ахуйн нэгжүүд, гэрээний харилцаанд орсон иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа гэж найдаж байна. Энэ бол “өндөржүүлсэн бэлэн байдлын” үеийн эдийн засаг, бизнесийн нэг гол чиглэл юм.
6. Төсвийн бодлого

Уламжлалт, тогтсон үзэл баримтлалын дагуу бол эдийн засгийн бууралт, хямралын үед төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн сахилга батыг сахих, алдагдлыг багасгах нь чухал. 2020 оны төсөв алдагдалтай батлагдсан бөгөөд алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь дотоод болон гадаад эх үүсвэр. Энэ эх үүсвэр хэр зэрэг тогтвортой хадгалагдах вэ гэдгийг анхаарах нь чухал. 2020 оны төсөв, төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ, төсвийн орлогын бүрдэлд, зарлага санхүүжилтийн бүх тооцоо, төсөөллийг эдийн засгийн өсөлт хэвийн байх орчноор тооцоолж хийсэн. Одоо энэ байдал өөрчлөгдсөн. Тиймээс төсвийн тодотгол хийх зайлшгүй шаардлага, ингэхлээр УИХ-ын ээлжит бус чуулган зарлан хуралдуулах зайлшгүй шаардлага үүсч байна. УИХ-ын ээлжит бус чуулган зарлахгүйгээр, төсвийг батлагдсан байдлаар нь эсвэл “зарлагыг шахаж хэмнэх”, орлогын урсгалд зохицуулах замаар төсвийн биелэлтийг хангаж болох ч төсвийн бодлого талаасаа харвал хариуцлагагүй хандлага юм. Төсвийн алдагдлыг тоо хэмжээнийх нь хувьд зайлшгүй тодотгох, төсвийн орон зайг тоо хэмжээний хувьд төдийгүй агуулгын хувьд үүсээд буй орчин нөхцөлд тохируулан бий болгох шаардлага үүсч байгаа тул зарлага санхүүжилт, хөрөнгө оруулалт, урсгал зарлага талаас нь, төсвийн орлогын хувьд орлогын тасалдал, үргэлжлэх хугацаа, үр нөлөө талаас нь авч үзэн 2020-2021 оны төсвийн бодлого, эдийн засгийн өсөлтийн төсөөллөө шинэчлэх хэрэгтэй. Хэрэв би андуураагүй бол төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд төсвийн тодотголыг хийх шаардлага нөөцийн нэг нь “force majeure” нөхцөл байдал үүссэн үед гэсэн агуулгатай заалт байгаа.

7. Мөнгөний бодлого

Олон орны төв банкнууд мөнгөний бодлогын төлөв байдлын хатууруулахгүй хэвээр нь хадгалах эсвэл зөөллөх, эдийн засгийн идэвхжлийг хангахад мөнгөний бодлогоор нөлөөлөх, тухайлбал, “тоо хэмжээний хөнгөвчлөлийн” (“quantitative easing”) төрийн бодлогыг хэрэгжүүлж байна. Корона вирусийн тархалтаас өмнө глобал эдийн засгийн бууралтыг угтаж ийм бодлого хэрэгжүүлж байсан, корона вирусийн тархалтын глобал эдийн засгийн нөлөөлөл, үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор дээрх бодлогыг үргэлжлүүлэн, эрчимтэй хэрэгжүүлж байна. Энэ хандлага ямар ч гэсэн 2020-2021 онд хадгалагдах төлөвтэй байна. Монгол улсын төв банкны хувьд мөнгөний бодлогын төлвийг accommodative буюу зохицсон төлөв байдалд хадгалж бодлогын хүүг тогтвортой байлгах хандлагыг баримталж ирэв. Харин одоо мөнгөний бодлогын хороо үүссэн нөхцөл

байдлын орчинд санхүүгийн тогтвортой байдлыг ч хадгалах, эдийн засгийн идэвхжлийг ч дэмжих мөнгөний бодлогын хандлага, төлөв байдлын тодорхойлох шаардлагатай болж байна. Миний бодлоор мөнгөний бодлогын төлөвийг зохицсон төлөвөөс сулруулж зөөлрүүлэх, “тоо хэмжээний хөнгөвчлөлийн” бодлогыг тодорхой хэмжээ, хязгаарын дотор хэрэгжүүлэх нь зүйтэй. Ингэхдээ Засгийн газрын эдийн засгийг идэвхжүүлэх, болзошгүй хямралаас сэргийлэх бодлого гарч батлагдсаны дараа бодлогын дээрх хандлагыг хэрэгжүүлбэл зохих бөгөөд Засгийн газар өмнө дурдсан бодлогын арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлээгүй нөхцөлд дан ганц мөнгөний бодлогоор ямар ч үйл ажиллагаа хэрэгжүүлсэн үр дүн тааруу байх болно.

- 7.1. Мөнгөний бодлогын хүрээнд өөр нэг онцгой анхаарах асуудал нь валютын зах зээл дээр паник үүсэх, түүнийг хиймлээр үүсгэхээс урьдчилан сэргийлэх асуудал юм. Үүний нэг гол чиглэл нь валютын нөөцийг захиргааны аргаар хуваарилах буюу currency rationing гэж нэрлэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх, үүний тулд валютын захын оролцогчид болох арилжааны банкнуудтай нягт хамтран ажиллах, тэдний зүгээс валютын зах зээл дээр паник үүсгэх, хиймлээр эрэлтийг нэмэгдүүлэх спекулятив буюу дамын хүчин зүйлсийн нөлөөнд автахгүй байх, банкнууд, ББСБ-ууд харилцагчдынхаа валютын эрэлт, түүний менежментийг зөв хийх, төв банкнаас болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос энэ чиглэлээр тасралтгүй үр ашигтай мониторинг хийх, зөвлөмж өгөх, валютын хадгаламжийн өөрчлөлт, хадгаламж эзэмшигчдийн авир төрхийн судалгаа, мониторинг хийх нь чухал. Гэхдээ шил шилээ дарсан хяналт шалгалтаас татгалзах нь чухал.
- 7.2. Төв банкны хувьд валютын захын үйл ажиллагааны болон ханшийн хөдөлгөөнийг анхааралтай ажиглах, арилжааны банкнуудын валютын нөөцийн удирдлага, чөлөөтэй ба заавал байлгах нөөцийн хөдөлгөөнд тогтмол дүн шинжилгээ хийх, засгийн газрын үндсэн үүргийн нэг болох валютын нөөцийг нэмэгдүүлэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь бодлогын дэмжлэг үзүүлэх, валютын орлогыг голчлон бүрдүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагатай илүү хамтран ажиллах, валютын интервенц хийх тактик, арга хэрэгсэлдээ илүүтэй анхаарах нь чухал.
- 7.3. “Тоо хэмжээний хөнгөвчлөлийн” бодлогыг төв банкны тухай хуулиар хориогүй (ийм ойлголт бий). Гэхдээ бас урамшуулаагүй.

Гэхдээ шаардлага үүсвэл түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, орон зай бий. (Тэтгэврийн зээлийг тэглэхэд төв банкны оролцсон байдал ч үүнд хамаарна.) Уул уурхайн экспортын орлого хумигдаж валютын нөөцийн орох урсгал саарч буй нөхцөлд төв банк, арилжааны банкууд хамтран уул уурхайн бус экспортын орох урсгалыг нэмэгдүүлэх “тоо хэмжээний хөнгөвчлөлийн” бодлого хэрэгжүүлж болно. Тухайлбал, ОХУ руу олон жил махан консерв экспортолж найдвартай, эрэлт их нэмэгдэж буй энэ зах зээл рүү экспортоо эрс нэмэгдүүлэх боломжтой ч санхүүжилтийн эх үүсвэр нь дутаад явж буй компани байна. Энэ мэт аж ахуйн нэгжүүдтэй уулзаж зорилтот зах зээл, тодорхой бүтээгдэхүүний экспорт дээр суурилсан санхүүжилтийн схем гаргаж болно.

Дарамт нь нэмэгдэж буй өрийн удирдлага, олон улсын эдийн засаг, санхүүгийн байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах, тэдний зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр хийх үйл ажиллагаанууд тодорхой байгаа тул энд дурдсангүй, гол нь эдийн засгийг идэвхжүүлэх, болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх талаар юу хийвэл зохил тойг дурдлаа. Өнгөрсөн хямрал, хүндрэлүүдийн гол сургамж бол хувийн хэвшилд түшиглэх, тэдний дуу хоолойг сайн сонсож хамтран ажиллах, зах зээлийн эрх чөлөөг хаалгүйгээр харин ч илүү нээж өгөх нь гол шийдэл, гарц байдаг гэсэн өгүүлбэрээр энэхүү зөвлөмжөө өндөрлөө.



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ


2019 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛ

Монголбанк
Судалгаа, Статистикийн Газар

АГУУЛГА

1. Дэлхийн эдийн засаг	40
2. Монголын эдийн засгийн өсөлт	41
3. Монголын инфляци	42
4. Өрх.....	42
5. Бизнесийн салбар	43
6. Мөнгө, зээл	43
7. Үйлдвэрлэлийн нөөц, хөдөлмөрийн зах зээл.....	44
8. Бүс нутаг, аж үйлдвэрлэл	45
9. Засгийн газар	45
10. Бүтээгдэхүүний үнэ.....	46
11. Төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позиц.....	46
12. Хүү.....	48
13. Хөрөнгийн зах зээл.....	50
14. Бонд.....	51
15. Валютын ханш	52
16. Банкны үзүүлэлтүүд.....	53

1. Дэлхийн эдийн засаг




Эх сурвалж: ОУВС, Блүүмберг


*Монголын экспортын гол орнууд: БНХАУ, ОХУ-ын экспортын хувиар жигтэсэн дундаж




Эх сурвалж: ОУВС, Блүүмберг



Эх сурвалж: ОУВС, Блүүмберг




Эх сурвалж: ОУВС




Эх сурвалж: ОУВС


* ХҮҮ-ээр тооцсон инфляци



Эх сурвалж: ОУВС






Эх сурвалж: Блүүмберг






Эх сурвалж: Блүүмберг


2019 оны 3 дугаар улирал




2. Монголын эдийн засгийн өсөлт



3. Монгол улсын инфляци




Эх сурвалж: ҮСХ




Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

*Суурь инфляцийг тооцохдоо ХҮ-ийн сагснаас үнийн хэлбэлзэл хамгийн ихтэй мах, сүү, ногоо гэх мэт 37 бүтээгдэхүүнийг хасч тооцов.




Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

4. Өрх



Эх сурвалж: ҮСХ




Эх сурвалж: ҮСХ

*Арилжааны банкуудаас иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл



Эх сурвалж: Тэнхлэг зууч ххк







Эх сурвалж: Монголбанк




5. Бизнесийн салбар



6. Мөнгө, зээл







7. Үйлдвэрлэлийн нөөц, хөдөлмөрийн зах зээл





2019 оны 3 дугаар улирал


8. Бүс нутаг, аж үйлдвэрлэл



9. Засгийн газар




10. Бүтээгдэхүүний үнэ




* Эрчим хүч = нүүрс, газрын тос, байгалийн хий, Метал, эрдэс = зэс, төмрийн хүдэр, цайр г.м
Үнэт металл = алт, мөнгө, цагаан алт; ХАА = хүнс, ундаа, ХАА-н гүүхийг эд




11. Төлбөрийн тэнцэл



2019 оны 3 дугаар улирал




Эх сурвалж: Монголбанк, ГЕГ



Эх сурвалж: Монголбанк



Эх сурвалж: Монголбанк








Эх сурвалж: Монголбанк






Эх сурвалж: Монголбанк, ГЕГ





12. Хүү







2019 оны 3 дугаар улирал



13. Хувьцааны зах зээл




14. Бонд




15. Ханш

Төгрөгийн ханш




Эх сурвалж: Монголбанк

Үйлчилж буй ханшийн индекс




Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн ханш



Эх сурвалж: Монголбанк

АНУ-ын доллар




Эх сурвалж: investing.com

Гадаад валютын албан нөөц




Эх сурвалж: Монголбанк


16. Банкны үзүүлэлтүүд




Эх сурвалж: УСХ



Эх сурвалж: Монголбанк



Эх сурвалж: Монголбанк



Эх сурвалж: Монголбанк

* Эдийн засгийн харьяат бусын харилцах, хадгаламж орсон

